

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-21

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 22-84

---

<i>1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	22-37
<i>2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	37-56
<i>3.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	56-84

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Төсвийн байнгын хорооны  
08 дугаар сарын 22-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 56 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Дамдинням;

Тасалсан: Н.Алтанхуяг, Б.Батцэцэг, Х.Болормаа, Ж.Ганбаатар, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Гангэрэл, Н.Ууганбаатар, А.Энхбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Хангал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, мөн газрын ерөнхий

санхүүч Ц.Амгалан, шинжээч Т.Отгонжаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Ганхуяг, мөн газрын ахлах шинжээч Г.Базаргүр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Батсүх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Ганцэцэг, Кибер аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Хилийн боомтын захиргааны хэлтсийн дарга Я.Дүгэржав, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх Б.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Ажлын хэсгийн тусгайлсан саналыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс гаргасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

### **Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

**“5 дугаар зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “, 6.5 дахь хэсгийн “нэмэгдүүлэх, 6.4-т заасан хугацааг сунгахыг” гэснийг “нэмэгдүүлэхийг” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “2025” гэснийг “2024” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “19.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 6.1.2-т” гэснийг “Энэ хуульд” гэж тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “19.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 6.1.2-т” гэснийг “Энэ хуульд” гэж тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Жаргалан нарын гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан, Төслийн 6.1.2-т заасан төсвийн тэнцлийн тусгай шаардлагыг өөрчлөхгүй хэвээр үлдээх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан, Төслийн 6.1.3-т заасан төсвийн зарлагын тусгай шаардлагыг өөрчлөхгүй хэвээр үлдээх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 15  
Бүгд: 17  
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдааны дэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа тайлбар хийв.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 3 дахь заалтын “орлогын хэмжээ” гэснийг “орлогын доод хэмжээ” гэж, 9 дэх заалтын “санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ” гэснийг “хуваарилах зардлын дээд хэмжээ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 4 дэх заалт буюу “Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ” 2025 онд “32,992.0” гэснийг “31,901.6” гэж, 2026 онд “35,849.5” гэснийг “34,967.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “34.7” гэснийг “33.6” гэж, 2026 онд “34.2” гэснийг “33.4” гэж, үзүүлэлтийн 5 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл” 2025 онд “-2,990.7” гэснийг “-1,900.3” гэж, 2026 онд “-2,975.9” гэснийг “-2,094.1” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “-3.1” гэснийг “-2.0” гэж, 2026 онд “-2.8” гэснийг “-2.0” гэж, үзүүлэлтийн 6 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ” 2025 онд “28,101.0” гэснийг “27,010.6” гэж, 2026 онд “30,779.5” гэснийг “29,897.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “29.6” гэснийг “28.4” гэж, 2026 онд “29.4” гэснийг “28.6” гэж, үзүүлэлтийн 7 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл” 2025 онд “1,900.3” гэснийг “2,990.7” гэж, 2026 онд “2,094.1” гэснийг “2,975.9” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “2.0” гэснийг “3.1” гэж, 2026 онд “2.0” гэснийг “2.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

### **Гурав.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 20 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Гангэрэл, Н.Ууганбаатар, А.Энхбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Хангал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, мөн газрын ерөнхий санхүүч Ц.Амгалан, шинжээч Т.Отгонжаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Ганхуяг, мөн газрын ахлах шинжээч Г.Базаргүр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Батсүх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Ганцэцэг, Кибер аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Хилийн боомтын захиргааны хэлтсийн дарга Я.Дүгэржав, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх Б.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Аж

үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нар тус тус танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа тайлбар хийв.

Мөн хуралдааны санал хураалт явуулах дэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур тайлбар хийв.

*Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгогдох санхүүжилтийг 34.5 тэрбум төгрөгөөр бууруулж, орон сууцны санхүүжилтийн зориулалтаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын төсвийн багцыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томъёоллын 1 дүгээр хавсралтад тусгагдсаны дагуу нийт 31,314.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 13,907.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг хасах, 2024 онд 44,307.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 16,833.7 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.



**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томьёоллын 1 дүгээр хавсралтад тусгагдсаны дагуу нийт 31,314.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 13,907.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг хасах, 2024 онд 44,307.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 16,833.7 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томьёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсаны дагуу 21,886.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 17,317.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл, арга хэмжээг нэмж, 124,488.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 18,055.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 13,423.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хавсралтад тусгагдсаны дагуу 3,566.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томьёоллын 3 дугаар хавсралтад тусгагдсаны дагуу дүнд өөрчлөлт оруулахгүйгээр 5 төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршлыг өөрчилж, 1 төсөл, арга хэмжээний ерөнхийлөн захирагчийг тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах санал:

1.Хавсралтын 10.1.1.1 дэх дэд заалтын “санхүүгийн” гэсний дараа “тайлангийн” гэж, 28.2.4.3 дахь дэд заалтын “суралцагч” гэсний өмнө “сургуулийн” гэж, 28.4.2.2 дахь дэд заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж тус тус нэмж, хавсралтын нэрийн “захирагч нарын” гэснийг “захирагч бүрийн” гэж, 4.1.1 дэх заалтын “хэргийн эзлэх хувь” гэснийг “хэрэг” гэж, 9.1 дэх хэсгийн “сахин хамгаалах” гэснийг “хангах” гэж,

10.1.1.2 дахь дэд заалтын “Санхүү нийцлийн” гэснийг “Санхүүгийн тайлангийн” гэж, 10.1.1.3, 10.1.1.4 дэх дэд заалтын “Гүйцэтгэл нийцлийн” гэснийг “Гүйцэтгэлийн” гэж, 11.1.3.1 дэх дэд заалтын “Гомдол” гэснийг “Өргөдөл, гомдол” гэж, 12.1.1 дэх заалтын “Зохицуулалтын хүрээний салбарын” гэснийг “Зохицуулалттай” гэж, 14.1.4.1 дэх дэд заалтын “Шинэ” гэснийг “Шинээр боловсруулах” гэж, 17.1.1 дэх заалтын “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн” гэснийг “Төрийн өмчит компанийн” гэж, 21.1.1 дэх заалтын “чанарын менежментийн стандартыг хангуулна” гэснийг “стандартыг хангуулж, чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлнэ” гэж, 20.2.1.2 дахь дэд заалтын “хийх сургалт, гаргах лавлагаа” гэснийг “сургалт, лавлагаа” гэж, 22.3.3 дахь заалтын “Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалж” гэснийг “Ус бохирдох, усны нөөц хомстохоос хамгаалж” гэж, 23.2.1.1 дэх дэд заалтын “6.0” гэснийг “5.1” гэж, 28.2.2.2 дахь дэд заалтын “хүүхэд” гэснийг “суралцагч” гэж, 33.1 дэх хэсгийн “Эрчим хүч, уул уурхайн бодлого” гэснийг “Эрчим хүчний бодлого” гэж, 35.3.1.1 дэх дэд заалтын “Аялал жуулчлалын зам дагуу” гэснийг “олон улсын, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу” гэж, 39.1.1.1 дэх дэд заалтын “журмын” гэснийг “журмаар тогтоосон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XI.2.3.1.“Зэвсэгт хүчний тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2024-2024, төсөвт өртөг 40,576.3 сая төгрөг, санхүүжих дүн 40,576.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,811.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17

29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц дахь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зардлыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дахь Хоршооны зээл, цагаан алт хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэгийг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 16  
Бүгд: 17

5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, ангилал, төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам төслийн ТЭЗҮ, зураг, төсөв Улаанбаатар гэснийг Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ төслийн ТЭЗҮ, зураг, төсөл Улаанбаатар гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал**

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “1 дүгээр зүйл” гэснийг “1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 6.2 дахь хэсгийн 4 дэх заалтын “Хот байгуулалт,” гэсний дараа “барилга,” гэж, 2 дугаар зүйлийн “1 дүгээр” гэсний өмнө, 3 дугаар зүйлийн “2 дугаар” гэсний өмнө болон 4 дүгээр зүйлийн “3 дугаар” гэсний өмнө “энэ хуулийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 22 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Гангэрэл, Н.Ууганбаатар, А.Энхбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга

Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Хангал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, мөн газрын ерөнхий санхүүч Ц.Амгалан, шинжээч Т.Отгонжаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Ганхуяг, мөн газрын ахлах шинжээч Г.Базаргүр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Батсүх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Ганцэцэг, Кибер аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Хилийн боомтын захиргааны хэлтсийн дарга Я.Дүгэржав, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх Б.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс гаргасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороодын санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл нар тус тус танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг зүйл, заалт бүрээр хэлэлцэв.*

### **Нэг.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.2</sup> дахь хэсгийн “08 дугаар сарын 15-ны” гэснийг “8 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	8
Бүгд:	17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

*Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтын “7 дугаар сарын 8-ны” гэснийг “07 дугаар сарын 25-ны” гэж, 8.4.2 дахь заалтын “7 дугаар сарын 20” гэснийг “08 дугаар сарын 05-ны” гэж, 8.4.3 дахь заалтын “7 дугаар сарын 25-ны” гэснийг “08 дугаар сарын 10-ны” гэж, 8.4.4 дэх заалтын “8 дугаар сарын 15-ны” гэснийг “9 дүгээр сарын 01-ний” гэж, 8.4.5 дахь заалтын “9 дүгээр сарын 1-ний” гэснийг “09 дүгээр сарын 15-ны” гэж, 8.4.7 дахь заалтын “9 дүгээр сарын 25-нд” гэснийг “10 дугаар сарын 01-ний” дотор гэж, 8.4.8 дахь заалтын “9 дүгээр сарын 20-нд” гэснийг “09 дүгээр сарын 25-ны дотор” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Энхбаяр нарын гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 13  
Бүгд: 17  
23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Хоёр.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Энхбаяр нар үг хэлэв.

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “Барилгын” гэснийг “Барилга, байгууламжийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 36<sup>1</sup>.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36<sup>1</sup>.1.Улсын Их Хурлаас баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай аж ахуй эрхлэгчдийн тоо

хязгаарлагдмал тохиолдолд гүйцэтгэгчийг энэ зүйлд заасан аргаар сонгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 36<sup>1</sup>.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36<sup>1</sup>.9.Энэ зүйлийн 36<sup>1</sup>.1-д заасан төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газар өргөн мэдүүлж, Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан, Төслийн 36<sup>1</sup> дэх зүйлийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан, Төслийн 54.11, 54.12, 15.7 дахь заалтуудыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 13  
Бүгд: 17

23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 36<sup>1</sup>.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, цөөнх болов.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17

35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

*Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Засгийн газраас хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хувь хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн болон” гэснийг “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаас нэр хүндийг нь тодорхойлсон, тусгай мэдлэг, ур чадвартай хувь хүн, хуулийн этгээдээс зөвлөх үйлчилгээ авах шаардлагатай гэж Засгийн газраас шийдвэрлэсэн болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17

35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 3.3.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр цөөнх болов.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17

29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр нарын гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр цөөнх болов.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11



Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Тав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Зургаа.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсэг, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9 дэх хэсгийн “тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэлх хэмжээгээр хасаж хөнгөлнө” гэснийг “хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэлх хэмжээнээс хэтрэхгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.2 дахь заалтын “тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан барьж байгуулах, ашиглах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.3 дахь заалтын “дуу, дүрс, дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9.6.спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын Үндэсний олимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9.7.Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургуульд, дотоодын магадлан итгэмжилсэн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн санал хураах төхөөрөмж ажиллахгүй байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.10 дахь хэсгийн “төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа;” гэснийг “боловсрол, эрүүл мэндийн

байгууллагын үйл ажиллагаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 14  
Бүгд: 17  
17.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.11 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 16  
Бүгд: 17  
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.11 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 15  
Бүгд: 17  
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “2031 он” гэснийг “2035 он” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Долоо. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Найм.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Ес.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Арав.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 37.1.3 дахь заалтын “хугацааг мөрдөх боломжгүй” гэсний дараа “тохиолдолд энэ хуулийн 37.1-д заасны дагуу хэлэлцээ хийж, гэрээ байгуулж болох бөгөөд төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэж нэмж, 37.1.3 дахь заалтын дугаарыг 37.7 дахь хэсэг болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 37.7 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн болон 2-оос дээш аймгийн нутаг дэвсгэр дамжин хэрэгжих” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Арван нэг.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төсөлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Арван хоёр.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “хамаарна” гэснийг “адилтгана” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Арван гурав.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Арван дөрөв.“Төрийн өмчийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

*Төслийн 2 дугаар заалттай холбогдуулан Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.“Тавантолгой түлш” ХХК-ийг нийслэлийн өмчид шилжүүлэхдээ хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, сайжруулсан төсвийн үнийг тогтвортой байлгахад шаардагдах нэмэлт санхүүжилтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг дээрх Ажлын хэсгийн гаргасан дээрх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал хураалтыг 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан эхлэхийн өмнө дахин явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 13  
Бүгд: 17  
23.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

*Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Арван тав. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 00 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 5 цаг 43 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 00 цаг 39 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
18 цаг 56 минут.

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Даваасүрэн:** Төсвийн байнгын хорооны гишүүдийн ирц 25-аас 14, 56 хувьтай байгаа учраас хуралдаан эхлэх боломжтой байна. Тэгээд бүртгүүлсэн гишүүдийг орж ирэхийг урьж байна. Тийшээ оруулчихъя гэсэн шүү дээ. Зарим нь орж ирээд суучхаг.

Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 56 хувьтай байгаа учраас Байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Би ирсэн гишүүдийг танилцуулаадахъя. Өнөөдрийн хуралдаанд миний бие, Далайн Батбаяр гишүүн, Ренчиндоржийн Батболд гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Дамбын Батлут гишүүн, Жадамбаагийн Баясгалан гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн нар бүртгүүлсэн байна. Зарим танхимд байхгүй гишүүд орж ирье.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя. 3 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. 1 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 24 оны 8 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна. 2 дахь асуудал бол Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хууль, хоёр дахь хэлэлцүүлэг. 3 дахь асуудал, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхээр байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна. хэлэлцэх асуудлаа батлах уу? Хэлэлцэх асуудлаа баталъя. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон дагаж өргөн мэдүүлсэн Тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эхлүүлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүд, ажлын хэсгийн дэд, мөн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын

зөвлөлийн дарга, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат, Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн Аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат байгаа юм уу? Сангийн яамны ТНБД байна уу? Ирж байгаа юм уу? Нансалын Тавинбэх ЭХЯ-ны ТНБД ирсэн байна. Сандагдоржийн Батболд ЗТЯ-ны ТНБД ирсэн байна уу? Дуудъя. Э.Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД байна уу? Дуудъя. Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, одоо дэд сайдгүй болсон учраас ТНБД нар оролцохгүй бол. Идэшийн Батхүү эдийн засгийн Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Батхүү байна уу? Батхүү байхгүй байгаа юм уу? Батхүү дуудъя. А.Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах газрын дарга, Ц.Ганцэцэг НДЕГ-ын дарга байна уу?

Зарим нь нөгөө Үндсэн хуулийн танхимд хуралдаж байгаа юм байна, цуглаж орж байгаа юм байна багтахгүй. Ц.Ганцэцэг НДЕГ-ын дарга, Баасанжавын Батхуяг Хяналт үнэлгээ, үндэсний хорооны даргын зөвлөх, Монгол Улсын сайдын зөвлөх гэж байгаа юм байна. Зоригтын Мөнх-Оргил ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсангийн Идэрцогт ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн

засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Ж.Отгонбат Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга, Ц.Ариунсанаа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ц.Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Б.Ганхуяг ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Л.Лувсан ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга, С.Цагаанхүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хөгжлийн зохицуулах газрын дарга, ЭМЯ-ны ТНБД байгаа юм уу Очирбат? Оролц, Очирбат байна. Б.Батцэцэг Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга байгаа юм уу? Батцэцэг.

Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга байна. Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга байна. Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга байна. Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга байна. Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга байна. Ч.Золбаяр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Кибер аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга, нөгөө танхимд байгаа юу? Я.Дүгэржав Боомтын сэргэлтийн үндэсний хорооны Хилийн боомтын захиргааны хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга байна уу? Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүү хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Лувсандоржийн



Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Рэнцэндоржийн Хангал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.

Б.Оюунгэрэл БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Б.Батсүх Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга. Эдгээр улсууд байна уу? Б.Отгонцэцэг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Ч.Ганбат Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга байна уу энэ улсууд ер нь? Очиржанцаны Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганбаатарын Энхтүвшин ЭХЯ-ны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Дугаржавын Амгалан НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга. Энэ хүн байна уу? Энэ нийслэлтэй холбогдолтой нэлээн юм байгаа шүү. Болдбаатарын Энхжин НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Базаргүр ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын ахлах шинжээч, Т.Отгонжаргал ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын нэгдсэн төлөвлөлт хариуцсан шинжээч, Ц.Амгалан ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч, Юрагийн Энхтуяа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Лувсандагвын Мөнхцацрал Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын менежер гэсэн хүмүүс оролцож байгаа юм байна. Байхгүй байгаа улсууд хуралд оролцоно шүү.

Ингээд би Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг

танилцуулъя. Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2024 оны 43 дугаар захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээр ахлуулан, 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг 2024 оны 8 дугаар сарын 16, 19, 20, 21, 22-ны өдрүүдэд нийт 5 удаа хуралдлаа. Ажлын хэсгийн танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар. 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн нэршилийг Төслийн тогтвортой байдлын тухай хуулийн өөрчлөлтөөр тусгаж, өргөн мэдүүлсэн нэр, томъёололтой нь нийцүүлэх өөрчлөлтийг хийв. 2.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг Тогтвортой байдлын тухай хуульд 2025 оны төсвийн жилээс хойш 2 хувийн алдагдалтай буюу ашигтай байхаар заасантай нийцүүлэн 2025, 2027 онуудад 2 хувийн алдагдалтай байх тооцооллын дагуу нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг бууруулах замаар холбогдох өөрчлөлтийг хийв.

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн

талаар. 1. Ажлын хэсгийн төсвийг хэлэлцүүлэгт бэлтгэн ажилласан талаар. Ажлын хэсгээс Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголын төсөлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээ, танилцуулга, санал, дүгнэлт, Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд хийсэн аудитын дүгнэлттэй танилцаж, хууль санаачлагч төсвийн төслийн орлого, зарлагын тооцсон үндэслэл, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй судалгааг гаргуулан авч ажиллалаа. 2. Төсвийн байнгын хороо ажлын хэсэгт оруулсан саналуудын талаар. Давхацсан тоогоор Улсын Их Хурлын 19 гишүүнээс төрийн болон төрийн бус 8 байгууллагаас албан бичгээр ирүүлсэн санал бүрийг хэлэлцэж, тодорхой зарчмыг баримтлан дэмжсэн дараах саналуудыг та бүхэнд танилцуулж байна. Үүнд: 1. Төсвийн захирагч хооронд зохицуулалт хийх төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр, чадал бүхий, чадал байршил өөрчлөх санал. 2. Зарлагын хэмжээ нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгасан урсгал болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах. 3. Төсвийн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн батлах хавсралтад тусгагдсан хөтөлбөрүүдийн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрчилсөн зэрэг болно.

Гурав. Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар. Байнгын хорооны хуралдаанаас шийдвэрлэсний дагуу хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн зарим зохицуулалттай холбоотойгоор Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс хууль зүйн урьдчилсан дүгнэлт гаргуулсныг ажлын хэсэгт хэлэлцэж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахаар

шийдвэрлэж, саналын томъёолол боловсруулан та бүхэнд хүргүүлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Төсвийн байнгын хорооноос Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хууль зүйн дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргаж ирүүлсэн байна. Уг дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Дондогмаа танилцуулна. Дондогмаа аль микрофон дээр байна вэ? Ажлын хэсгийн 6 юм уу? 6 дугаар микрофон дээр.

**Ч.Дондогмаа:** Төсвийн байнгын хорооны гишүүд болон энэ хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудын энэ оройн амгаланг айлтгая. Төсвийн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 19-ний хуралдаанаар шийдвэрлэж, Байнгын хорооноос Улсын Их Хурлын Тамгын газарт 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн УИХ 11/16 84 дугаартай албан бичгийг үндэслээд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс энэхүү дүгнэлтийг гаргасан болно.

Хууль зүйн дүгнэлтийг гаргахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасныг баримталсан. Төсвийн байнгын хорооны даргын албан бичигт

дурдсанаар ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн улсын төсвийн нэгдсэн, Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолуудын төслийн талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар тусгасан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төсвийн.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Уучлаарай байж бай даа. Энэ хууль зүйн дүгнэлттэй холбогдуулаад гишүүд асуулт асууя гээд байгаа юм байна. Тэгэхээр хууль зүйн дүгнэлтийг энэ танилцуулж байх хооронд тараая. Хууль зүйн дүгнэлтийг тараах арга хэмжээг манайхан аваадах, үргэлжлүүлье.

**Ч.Дондогмаа:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль бусад хуульд нийцэж байгаа эсэх талаар.

1 дүгээрт Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.1.2-т төсвийн тухай тусгай шаардлагыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах баримтлахад баримтлахаар, 9.1.1-д дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлахаар, 9.1.2-т төсөвт нэмэлт,

өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхээр тус тус заасан. Иймд цаашид Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл түүний дотор төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх зохицуулалт бүхий хуулийн төслийг бие даасан хуулийн хэлбэрээр боловсруулж, Улсын Их Хурлаар эцэслэн шийдвэрлүүлсний дараа дунд хугацааны төсвийн бодлогын баримт бичиг, тухайн жилийн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нийцүүлэн боловсруулж байх нь зүйтэй байна.

2 дугаарт төсвийн төслийн 2 дугаар зүйлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт буюу төсвийн тусгай шаардлага, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн жилийн, тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх гэснийг төсвийн, нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх гэж өөрчлөн найруулахаар тусгажээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр баталсан бөгөөд хуулийн 6 дугаар зүйлд төсвийн тусгай шаардлагыг хуульчилсан.

Тодруулбал төсвийн, төсөвт нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ээс 2 хувиас илүүгүй алдагдалтай эсвэл ашигтай байх. Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх, ЗГ-ын өнөөгийн, өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байх гэсэн 4 тусгай шаардлагыг заасан

бөгөөд өнгөрсөн хугацаанд ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 40 хувийг 60 хувь болгон өөрчилснөөс өөр зохицуулалт ороогүй байна.

Харин Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулийн 6.4-д энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жил хүртэл, 6.1.4-д заасан тусгай шаардлагыг 2024 оны төсвийн жил хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлж болно гэсэн зохицуулалтыг нэмсэн байсныг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчилж, өөрчлөн найруулж, 6.4 энэ хуулийн 6.1-д заасан тусгай шаардлагыг 25 оны төсвийн жил хүртэл, 6.1.4-д заасан тусгай шаардлагыг 25 оны төсвийн жилээс хэрэгжүүлнэ гэж өөрчлөн найруулсан байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд уг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтыг тусгасан бөгөөд 19.1-д энэ хуулийн 6.1.2-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жилээс, энэ хуулийн 6.1.3-д заасан төсвийн тусгай шаардлагыг 2017 оны төсвийн жилээс тус тус эхлэн дагаж мөрдөнө гэж заасан. Өөрөөр хэлбэл хуулийн 6.4 дэх хэсэгт заасан 6.1.2-т заасан тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жил хүртэл хэрэгжүүлнэ гэж заасан нь тус зохицуулалтыг 2025 оноос хэрэгжүүлэхгүй мэт боловч 19.1-д зааснаар 2025 оны төсвийн жилээс хэрэгжүүлэх буюу цаг хугацааны хувьд үргэлжилсэн шинжтэйгээр зохицуулсан байна.

2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилсан хууль санаачлагчдын хуулийн төслийн үзэл

баримтлал, хуулийн товч болон дэлгэрэнгүй танилцуулгад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.4, 5 дахь хэсгийг өөрчлөн найруулах талаар дурдаагүй, Засгийн газраас хуулийн төсөлд санал авахдаа уг агуулгыг тусгаагүй байсан. Мөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөлд эдгээр заалтыг нэмж тусган, хэлэлцүүлгийн шатад эдгээр заалтын талаар аль ямар нэг зарчмын зөрүүтэй санал гараагүй, өргөн мэдүүлснээрээ батлагдсан байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.1-д, 1 дэх хэсэгт 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл гэж гэсэн нэр томъёоллыг хэрэглэсэн. Харин өргөн мэдүүлсэн хуулийн төслөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн төсөлд тэнцвэржүүлсэн тэнцэл гэснийг нэгдсэн төсвийн суурь тэнцэл гэж өөрчлөн найруулахаар тусгасан хэдий ч хуулийн 19.9 дэх хэсэгт заасан зохицуулалтыг нийцүүлээгүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1.2, 30.1.3-д заасан хууль, хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нэг нэр томъёогоор өөр, өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, хоёрдмол утгагүй товч, тодорхой бичих гэсэн шаардлагыг хангаагүй байна.

Дүгнэлт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны 2025-аас 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр шинээр нэмж байгаа нэр, томъёоны тодорхойлолт, өөрчлөлт оруулж байгаа 6.1.2 дахь заалт, 6.1.4 дэх заалтын нэр томъёоны тодорхойлолттой холбоотойгоор хуульд ишлэл хийсэн зарим заалтад нэр томъёоны зөрчил үүсэхээр байгааг анхаарч, хэлэлцүүлгийн явцад залруулах шаардлагатай байна.

Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувьд эрх зүйн зөрчилгүй гэж үзсэн болно.

**Ц.Даваасүрэн:** Баярлалаа. Ингээд саяын хууль зүйн дүгнэлттэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Үгүй ээ яах вэ саяын яг тодорхой дурдсан энэ Тогтвортой байдлын хуулийн зүйлүүдтэй холбогдоод асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгчихье. Алга уу? Алга байна. Гишүүд асуулт авч, хариулт аваад, хариулт авлаа. Асуух гишүүн байсангүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт 39.10.Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024, 2025 оны төсвийн төслийн тухай хуулийн төслийн талаар санал хураалтыг явуулж эхлэх юм уу? Хэлэлцэж эхэлье. Энийг нь буруу явуулсан байна шүү дээ. Хэлэлцэж эхэлье. Үгүй ээ үгүй энэ нэг буруу юм яваад байх юм. Зүгээр л ингэе Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрээ өгье. Мөн Тогтвортой байдлын тухай хууль, Өрийн тухай хууль бүгд нь. Энэ эдгээр хуулиудаар. Батжаргал гишүүн. 3 хууль байна шүү дээ. Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн хүрээний мэдэгдлийг дагаж өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль. Эдгээр хуультай холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрийг авъя. Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр сая дүгнэлтэд их тодорхой орлоо шүү дээ. 6 дээрээ нэршлийн өөрчлөлт хийчхээд, 19 дээрээ өөрчлөлт хийгээгүй нь уг хууль доторх байгаа нэр томъёоллууд хоорондоо зөрөөд болж өгөхгүй байна гэдэг асуудал яригдчихлаа. Тэгэхээр үүнийг манай ажлын хэсэг сая ажиллахдаа ямархуу байдлаар анхаарсан юм бэ? Энэ дээр нэг хариу аваадахъя.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах билээ, хариулах хүн байна уу? Юу гэдэг асуулт байсан бэ? Ингэсэн байгаа 6.1.2-ын тусгай шаардлага өөрчлөгдсөн байгаа тийм ээ, тусгай шаардлага өөрчлөгдсөн байгаа. Түүнтэй холбогдуулаад 6.4 гэдэг заалт болбол шаардлагагүй болчхож байгаа юм. Нөгөө нэг будилуулаад байгаа заалт байна шүү дээ, нөгөө 6.1.2 дээр байсан төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 25 он хүртэл хэрэгжээд л дуусчих юм байна гээд ойлгоод байсан шүү дээ. Тэгээд тэр чинь бол угаасаа тэр 6.1.2 дахь шаардлага өөрчлөгдөж байгаа учраас тэр 6.4 байхгүй болчхож байгаа.

Харин таны асуугаад байгаа Төсвийн тогтвортой байдлын хуульд бол тусгай шаардлага 2 шаардлага өөрчлөгдөж байгаа. 6.1.2 энэ болбол төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ заасан ийм шалгуур байсан. Одоо энэ болбол төсвийн суурь тэнцлийн хэмжээ болж өөрчлөгдөж байгаа юм. Нэмэх 2, нэмэх 2-оос доошгүй байхаар билүү тийм ээ? Тийм нэмэх 2 байна гэж. 6.1.3 нь болохоор төсвийн урсгал зардал ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байна гэсэн ийм 2 шалгуур болж өөрчлөгдөж байгаа юм.

19.9 дээр тэр 6.4 дээр байсан 6.1.2 буюу тэнцвэржүүлсэн тэнцлийн үе шаттай хэрэгжүүлэх хугацааг зохицуулсан байгаа. Гэтэл энэ дээр болохоор 25 оноос хойш төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2 хувиас хэтрэхгүй байна гээд ингээд заачихсан заалт байгаа юм. Гэтэл энэ заалттай

Төсвийн хүрээний мэдэгдлийн нөгөө 25, 26 оны заалтууд нийцэхгүй байсан. Тийм учраас бид нар нийцүүлээд өөрчилчихсөн байгаа. Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -3,1 байсан нь -2, 26 онд -2,8 байсан нь -2 болгож ингэж өөрчилсөн байгаа. Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Би сая хууль зүйн дүгнэлттэй холбогдуулаад нэг тодруулах зүйл байгаад байна. Сая хууль зүйн дүгнэлтийг уншихад бас л яах вэ сая Батжаргал гишүүний асуусан л асуулт байгаад байгаа юм л даа. Нэг талдаа нэгдсэн төсвийн суурь тэнцэл гэж өөрчлөн найруулж орж ирж байгаа хэдий ч яг энэ 19.9 дэх заалтууд дээр энэ зохицуулалтууд нь өөрөө нийцэгдээгүй байна гэдэг асуудал яригдаад байдаг. Тэгэхээр энэ угаасаа Хууль тогтоомжийнхоо хуулиараа ингээд нэг ийм хоёрдмол утгатай, тодорхой бус нэг ийм зүйл болчихоод байдаг. Хууль тогтоомжийнхоо хуулийн шаардлагыг бас хангаагүй байгаад байдаг нэг ийм асуудлыг ер нь яг манай Тамгын газрынхан бас юу гэж үзэж байгаа юм бэ? Хууль зүйн талаасаа.

Тэгэхээр уг нь эхнээсээ л суурь саяын тэр тэнцэл ч гэнэ үү юу гэж нэр томъёо нь өөрчлөгдөнө үү бүхий л тэр б дахь бүлэг дээрээ ч байна уу, 19 дэх бүлэг дээрээ ч байна уу бүх л тэр хууль дээрээ хууль зүйн талаасаа, бичвэр талаасаа алдаа мадаггүй л нийцүүлж л уг нь оруулж ирэх ёстой байсан зүйл. Тэгэхээр ийм хоёрдмол утгатай л хуулийн төсөл орж ирчхээд байгааг ер нь манай Тамгын газрынхан яг юу гэж үзэж байгаа юм бэ? Яг хууль өргөн барих энэ шаардлагуудаа хангаж байна гэж үзэж байгаа юм уу, үгүй гэж үзэж байгаа юм уу? Энэ дээр яг ямар байр суурьтай байгаа юм бэ?

**Ц.Даваасүрэн:** Энэ нөгөө Төсвийн тогтвортой байдлын хуулийн талаар гаргасан манай хуулийнхны дүгнэлт дээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9 дэх хэсэгт 6.1.2-т заасан

нэгдсэн төсвийн тэнцсэн тэнцэл гэсэн томъёоллын хэрэглэсэн байна. Харин өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл гэснийг нэгдсэн төсвийн суурь тэнцэл гэж өөрчлөн найруулахад тусгасан хэдий ч 19.9 дэх хэсэгт заасан зохицуулалттай нийцүүлээгүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 10-ын биш ээ, 30.1.2, 30.1.3-д заасан хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтоор илэрхийлэхгүй байх, хоёрдмол утгагүй, товч тодорхой бичих байх гэсэн шаардлагыг хангаагүй байна гээд ийм дүгнэлт гарсан учраас бид нар 19.9.9-д нийцүүлэх арга хэмжээг аваад, төсвийн хүрээний мэдэгдлийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээг 25, 26 онуудад одоо энэ өргөн, одоо өргөн мэдүүлсэн байгаа Төсвийн тогтвортой байдлын хуулийн 19.9-ийн дагуу болгож өөрчилсөн байгаа. Хуульд нийцүүлэх арга хэмжээг нь авсан байгаа.

Гишүүд асуулт асууж дууслаа. Энэ саяын дурдсан Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн тогтвортой байдлын хууль, төсвийн биш ээ, Өрийн удирдлагын тухай хуультай холбогдуулаад зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Тэгвэл саналаа өгье, өгчих. Тийм. Тэмүүлэн гишүүнийг саналаа бичиж байх хооронд тэр энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуультай холбогдуулаад ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулж эхэлье. Чи наад утсаа боль л доо. Ингээд хураалгаад явчих нь зөв биз дээ.

Ажлын хэсгээс гаргасан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх.

“5 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн цаашид ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 17 гишүүнээс 9, 52,9 хувийн саналаар дэмжигдсэн байна.

2.Төслийн 3 дугаар зүйлд “, 6.5 дахь хэсгийн “нэмэгдүүлэх, 6.4-т заасан хугацааг сунгахыг” гэснийг “нэмэгдүүлэхийг” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саналыг 17-гоос 9 гишүүн дэмжиж, 52,9 хувиар дэмжигдсэн байна.

3 дахь санал. Төслийн 3 дугаар зүйлд “19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “2025” гэснийг “2024” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёолол санал хураалт явуулъя. Уг саналыг 17-гоос 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар дэмжигдсэн байна.

4 дэх санал. Төслийн 3 дугаар зүйлд “19.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 6.1.2-т” гэснийг “Энэ хуульд” гэж тус тус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ чинь буцааж яахгүй бол болохгүй. Яагаад гэвэл энэ үгийг хасахгүй бол энэ заалт өөр болчихсон юм, агуулга нь өөр болчихсон байхгүй юу. 17 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 35,3 хувиар энэ санал

дэмжигдээгүй байна. Аубакир гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргая.

**Т.Аубакир:** Сая дэмжиж санал өгсөн боловч аппарат ажилласангүй. Тийм учраас саяын саналыг хүчингүй болгоод, дахин санал хураалгаж өгнө үү.

**Ц.Даваасүрэн:** Аубакир гишүүний горимын саналаар саяын хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Горимын санал 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар дэмжигдсэн байна. Тийм учраас өмнөх үндсэн саналыг дахиж хураая. Төслийн 3 дугаар зүйлд “19.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 6.1.2-т” гэснийг, 6.1.2 нь байхгүй болчихсон гэсэн үг, гэснийг энэ хуульд гэж тус тус нэмэх. Өөрчлөгдчихсөн шүү. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Саяын саналыг 17 гишүүнээс 9, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувиар дэмжигдсэн байна.

Тэмүүлэн гишүүн, Жаргалан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хуулийг, хуулийн төслийг хуульд хууль санаачлагчид нь буцаах гэсэн ийм санал гаргаж байгаа юм байна. Бүх юм буцна гэсэн үг. Тайлбарлая. Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

**Г.Тэмүүлэн:** Би энэ ЗГ-аас төсвийн хүрээний мэдэгдэл дагуулж хамтад нь өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг ЗГ-т буюу хууль санаачлагчид нь болбол буцаах саналыг болбол гаргаж байгаа. Манай шинэ гишүүд бас төдийлөн сайн мэдэхгүй байж магадгүй. Төсвийн хүрээний мэдэгдэл буюу Монгол Улсын дунд хугацааны энэ төсөв санхүүгийн бодлогын баримт бичгийг болбол бид нар удаа дараа болбол өөрчилж ирсэн. Жил болгоныхоо төсвийг дунд хугацааныхаа бодлоготой, бодлогыг нэг жилийнхээ төсөвтэй нийцүүлж дандаа өөрчилж ирсэн зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр

үндсэндээ болбол Монгол улс сүүлийн миний мэдэхийн 15 жилийн хугацаанд ямар нэг төсөв санхүүгийн бодлогогүй бол явж ирсэн гэж хэлэх гээд байгаа юм.

Үүнийг хязгаарлах гол Үндсэн хууль шиг шахуу хэлбэрэлтгүйгээр мөрдөж байх ёстой хууль болбол манай Төсвийн тогтвортой байдлын тухай хууль байгаа юм. Бид нар 2010 онд эдийн засгийн хямралын дараа болбол, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын дараа болбол ирээдүйд учрах төсөв санхүүгийн эрсдэлээс хамгаалах үүднээс болбол энэ хуулийг анх гаргаж байсан юм. Ингээд үндсэндээ 14 жилийн хугацаанд энэ хуульд удаа дараа жилдээ 1-ээс 3 удаа гар дүрж, зөвхөн энэ төсвийн тусгай шаардлагуудыг өөрчилж байсан. Өрийн алдагдал, өрийн хязгаар, төсвийн алдагдал, хэрэгжиж байсан түүх бараг байхгүй. Бид нарын заасан дээр 2 хувь, 60 хувь гэсэн тоонууд хэзээ ч хүрч байсан түүх байхгүй. Үндсэндээ бид нар боломжит бүх боломжоо болбол энэ өнгөрсөн хугацаанд алдаж байсан юм.

Тэгэхээр би болбол Сангийн яам энэ том бодлогын Үндсэн хууль шиг шахуу хуулийг өөрчилж орж ирж байгааг болбол би буруушааж байгаа. Та нар нэг жилийнхээ төсвийг, тэр дундаа бүүр төсвийнхөө тодотголыг энэ бодлогынхоо баримт бичигтэй нийцүүлж, түүнд заасан тусгай шалгуурт нийцүүлж, энэ Үндсэн хууль шиг Төсвийн тогтвортой байдлын хуульдаа нийцүүлж орж ирэх ёстой юмыг жилийн жилд ингэсээр орж ирсэн. Өнөөдөр орж ирж байгаа зүйл бол энэ суурийн агуулгыг нь бүүр сууриар нь байхгүй болгож байгаа юм. Энэ хууль цаашид байх шаардлагагүй болж байна. Байх шаардлагагүй болох гэж байна. Ийм суурь том зарчмын өөрчлөлтийг бид бүхний өмнөх алдаа оноо, сорилт бэрхшээл дээрээ тулгуурлаж гаргасан энэ зарчмын томоохон олон улсын нийтлэг жишгээс аваад боловсруулсан хуулийг үндсэндээ сууриар нь байхгүй болгож байна.

Суурь, суурь зарлага, суурь тэнцэл гэнэ. Бараг олон улсад хаана ч байхгүй бараг сонсож байгаагүй ийм зүйлээр юу гэдэг юм өнгөлөн далдлалт байдлаар өөрсдийгөө хуурч, дахиад ийм 2 төсөвтэй юм шиг, нэг талдаа магадгүй цэвэрхэн харагдаж магадгүй л дээ төсөв. Гадаад бонд, өр зээл, үнэт цааснууд нь тэнд орохгүй, тэгээд хэдэн их наядаар энэ ирэх 3, 4 жилийн хугацаанд нэмэгдэх юм. Энэ жилийнх нь л лав 3,1-ээр нэмэгдэж орж ирж байна. Ирэх 3 жилийн хугацаанд лав магадгүй энэ төсөөллөөрөө болбол 12, 3 их наядаар нэмэгдэх биз. Тэгэхээр цаашидаа яах юм бэ гэдэг асуудлууд байгаа. Би ийм суурь тэнцэл шинэ ойлголт гаргаж ирж, шинэ нэр томъёо гаргаж ирж ингэж болбол юу гэдэг юм улс орныхоо ирээдүйг тоглож болохгүй. Төсөв санхүүгийн аюулгүй байдал гэдэг бол өөрөө амин чухал асуудал.

Бид нар энэдээ ч нийцүүлж удаа дараа Улсын Их Хурал болбол яах вэ сайжруулах оролдлогуудыг болбол хийж байсан. Одоо бол энэ шиг ийм буруу муу хувилбар болбол хэзээ ч орж ирж байгаагүй. Дэмжихгүй. Би тэгэхээр энийг болбол хууль санаачлагчид буцаах ёстой. Хууль санаачлагч энэ хуулийг үндсэндээ агуулгаар нь болбол байхгүй болгож байна л гэдэг ийм зүйл болбол байгаа. Тэгэхээр би энийг болбол хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэсэн саналыг болбол бас гаргаж байгаа шүү. Тэгээд гишүүд болбол бас анхааралтай хандаарай. Төсвийн байнгын хорооны гишүүд бол та бүхэн энэ төсөв санхүүгийн аюулгүй байдалтай холбоотой, улс орныхоо ирээдүйтэй холбоотой, эрсдэлтэй холбоотой асуудлууд дээр болбол бас нухацтай хандаж шийдвэрээ гаргана гэдэгт бол би бас итгэлтэй байгаа.

**Ц.Даваасүрэн:** Болохгүй, яах вэ би нөгөө ажлын хэсгийн ахлагчийн хувьд тайлбар хэлж болно. Тэмүүлэн гишүүний яриад байгаа энэ асуудал дээр нөгөө



суурь тэнцэл суурь, зарлага гэж юм ороод ирчихсэн. Суурь тэнцлийг гаргахдаа нөгөө зарлагад бид нар нөгөө зээлээр санхүүжиж байгаа зарлагыг л тооцохгүй болчихсон байгаад байгаа юм. Жишээлбэл зээлийн хөрөнгөөр зээл ашиглаад зам санхүүжүүлж байгаа энэ зарлагуудыг болбол тооцохгүй байна гэдэг ийм санаа. Тэгэхдээ яах вэ бид нар нэлээн ярьсан юм энэ дээр. Яриад яах вэ нөгөө хэдийгээр өнөөдөр ингээд зээл аваад санхүүжүүлж байгаа нь эрсдэлгүй, гэхдээ энэ ирээдүйд эрсдэл үүсгэж байгаа юм. Ирээдүйд үүсгэж байгаа эрсдэл гэдэг агуулгаар нь бол бид нар өрийн нөгөө шалгуур нь байгаад байгаа юм ДНБ түүний 60 хувиас өрийн хэмжээ хэтрэхгүй гэдэг. Энэ шалгууртаа барина гэдэг агуулгаар нь бол бид нар энийг бас яах вэ дэмжсэн байгаа.

Гэхдээ ер нь болбол бас зарчмын хувьд бид нар цаашидаа бас энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд бол ингээд байнга өөрчлөлт оруулаад явах ийм жишиг тогтох юм бол буруу. Тийм учраас энэ удаа бол бүтээн байгуулалт, хамтраад юм хийж байгаа гэдэг дээр нь болбол яах вэ, ирээдүйд үүрэх эрсдэлээ, зээлийн эрсдэлээ, өрийн эрсдэлээ ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй гээд нэрлэсэн үнээр ингэж хязгаар тавьчихаж байгаа учраас бол өрийн дарамт үүсэхгүй гэдэг агуулгаар бид дэмжсэн байгаа.

Ингээд Тэмүүлэн гишүүний саналаар санал хураалт явуулъя. Дэмжигдэх юм бол бүх юм буцна гэсэн үг. Ингээд Төсвийн тогтвортой байдлын хуулийг хуулийн төслийг санаачлагчид нь буцаая гэдэг ийм саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Тэмүүлэн гишүүний гаргасан горимын саналыг 17-гоос 3 гишүүн буюу 17,6 хувь нь дэмжсэн байгаа учраас дэмжигдсэнгүй.

Дараагийн асуудал. Эд нарыг бас хураалгах юм уу? Танилцуулах уу? Танилцуулах биш хураах юм уу, хураах юм уу? Дэгийн тухай хуулийн хэдийн хэд вэ?

Тэрийг гаргаад ир. АН-ын бүлгээс бас зарчмын зөрүүтэй санал гаргаж ирүүлсэн юм байна. Тэгээд нөгөө Дэгийн тухай хуулийн 39.14-өөр гишүүд, нам, эвслийн бүлэг 39.17-д заасан зарчмын зөрүүтэй саналаа хууль тогтоомжийн төслийг яаралтайгаар хэлэлцэж байгаагаас, яаралтай горимоор хэлэлцэж байгаа бусад тохиолдолд гэж байна шүү дээ. Байгууллагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо, чуулганы анхны хэлэлцүүлгийг явуулахаас ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байна. Үгүй горимоор хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд гэж байна шүү дээ. Энэ чинь яаралтай горимоор явж байгаа шүү дээ. Яаралтай горимоор явж байхад энэ чинь хэлэлцэхгүй юм байна шүү дээ. Энэ чинь яаралтай горимоор явж байгаа шүү дээ.

АН-ын бүлгээс зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн энийг Дэгийн тухай хуулийн 39.14, 17-гоор бол танилцуулаад, санал хураалт явуулах ёстой юм байна. Энэ саналаа, энэ саналыг нь би танилцуулах ёстой юу? Аль эсвэл зүгээр ингээд тайлбарлах, би унших ёстой юм уу, уншина гэж байхгүй юм биш үү? Ирүүлсэн байна л гэж байна шүү дээ. Танилцуулна гэж байхгүй юм байна шүү дээ. Ирүүлчихсэн харин тийм. Танилцуулна гэж хаана байгаа юм бэ? Зүгээр тайлбарлаж болно гэж байна шүү дээ. Тайлбарлаж болно л гэж байгаа биз, танилцуулна гэж байхгүй юм байна л даа.

Би уншаад танилцуулчихъя. Зүгээр яах вэ уншиж танилцуулна гэж байхгүй юм байна. Энийгээ АН-ын бүлгээс тайлбарлаж болох юм байна шүү. Санал хүргүүлэх тухай АН-ын бүлэг. АН-ын бүлгээс дараах саналуудыг гаргаж ирүүлсэн байна.

#### 1.Зарчмын зөрүүтэй саналууд.

1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан төсвийн тэнцлийн тусгай шаардлагыг өөрчлөхгүй хэвээр үлдээх. Төсвийн тогтвортой байдлын

тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувьтай байх гэж өөрчлөн улмаар суурь тэнцэлд үнэт цаас, гадаад зээлээр хэрэгжих зардлыг тооцохгүй болбол төсвийн бодит алдагдал ихээр өсөж, ЗГ-ын өр нэмэгдэх эрсдэлтэй байхад л санал болгосон өөрчлөлтийг хүлээж авах боломжгүй хэвээр үлдээе гэсэн юм байна нэг дэх санал нь шүү. Тэгээд энийг хураах уу, хураахгүй гээд явах уу? Энэ саналаа тайлбарлах уу Ардчилсан бүлгээс? Алга. Тэгвэл энэ чинь хар аа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 6.1.2-т болохоор нөгөө суурь тэнцлийг оруулаад ирчихсэн байж байгаа шүү дээ, суурь тэнцэл гэдгийг. Гэтэл АН-ын бүлэг болохоор үгүй ээ, энийг өөрчлөхгүй, нөгөө хуучин төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл гэдгээр нь байлгана гэсэн юм байна. Энэ саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Энэ саналыг хуралдаанд оролцсон 17 гишүүнээс 3 нь зөвшөөрч, энэ санал дэмжигдээгүй байна.

2 дахь санал нь. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.4 дэх заалтыг хүчингүй болгох. Энэ хүчингүй болчихож байгаа учраас энийг хураалгах шаардлагагүй. Тийм ээ, тийм. Энэ бол нөгөө Ажлын хэсгийн саналд энэ санал хураагдаад хүчингүй болчихсон учраас энэ саналыг хураалгах шаардлагагүй.

3 дахь санал. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан төсвийн зарлагын тусгай шаардлагыг өөрчлөхгүй хэвээр үлдээх. Одоо бол өөрч, энэ ийм заалт байсан. 6.1.3 болбол нөгөө би уншаад өгчихье. 6.1.3 дахь заалтыг нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх гэж өөрчлөн, төсвийн нийт зарлагын өсөлтийг бол уурхайн бусад бус салбарын өсөлттэй уялдуулан хязгаарласан байгааг хүчингүй болгож, зөвхөн урсгал зардалд олон улсын дунджаас өндөр хэмжээ тогтоож өгвөл төсвийн зардал

хяналтгүйгээр тэлж, мөчлөг дагасан тогтворгүй байдал үүснэ гэж үзсэн юм байна.

Хуучин бол нөгөө нэг уул уурхайн бус бүтээгдэхүүний хувьтай харьцуулсан харьцаа байсан юм. Одоо орж ирж байгаагаар болбол төсвийн урсгал зардал ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй гэж ингэж өөрчилсөн. Энийг хуучнаар нь байлгая гээд байгаа юм байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан төсвийн зарлагын тусгай шаардлагыг өөрчлөхгүй хэвээр үлдээх гэсэн АН-ын бүлгээс гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ саналыг хуралдаанд оролцож байгаа 17 гишүүнээс 2 дэмжсэн байна. Энэ санал дэмжигдсэнгүй. Ингээд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр АН-ын бүлгээс ирүүлсэн саналыг хурааж дууслаа.

Дараагийн санал. Одоо ингээд Тогтвортой байдлын хуультай холбогдолтой саналууд дуусчихсан уу? Үгүй ээ үгүй Тогтвортой байдлынх нь дуусчихсан уу, дуусчхаагүй юм уу? Одоо төсвийн хүрээ рүү орох гээд байна уу? Энэ үнэн үү? Зүйл бүрээр нь асуулт байна уу, үг хэлэх үү гэдэг ийм юм руу орчихсон гээд байх юм. Хуучин чинь үгүй шүү дээ шууд хуулийн төслийг чинь нэгмөсөн л явдаг байсан шүү дээ. Биш ээ биш, одоо ингээд шинэчилсэн хуулиар та нар ингээд 70 зүйл ангитай хууль орж ирэхээр бүр 70, үгүй ээ үгүй хуучин тийм биш байсан байхгүй юу. Тухайн хууль дээр асуулт асуух уу, үг хэлэх үү гэж явдаг байсан чинь одоо зүйл бүр дээр асуулт асуух уу гээд асуучхаад, дараа нь ахиад үг хэлэх үү гэж хэлэлцэнэ гээд байгаа байхгүй юу. Одоо тэгье гээд байгаа байхгүй юу. Үгүй ээ үгүй, тэгж яваагүй, яалаа гэж дээ, биш ээ биш, үгүй үгүй, тэгээгүй. Шинэ юугаар дэгээр зүйл бүрээр нь биш, зүйл бүрээр нь биш байхгүй юу Батжаргал би мэдэлгүй яах вэ. Үгүй ээ худлаа, би энэ чинь тэгээгүй ээ тэгээгүй. Үгүй ээ үгүй.

Одоо ингэх юм байна шүү. Тэгээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 24, 25, 26 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өг, нэрээ өг, одоо ингэж хэлэлцэх юм байна лээ. Асуух асуулт байсангүй. Үг хэлэх гишүүн байна уу? Асуулт байхгүй юм байна. Нэрээ өгнө шүү. Алга байна. Үгүй ээ үгүй хэлэлцэнэ гээд байгаа шүү дээ санал биш, асуух асуулт л гэсэн биз дээ? Яах вэ дэгээр нь л явъя. 6 номерын микрофоныг өгье. Ингээд би заавал асуулт асуух уу, үг хэлэх үү гээд яваад байх юм уу?

**Ч.Дондогмаа:** Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10 дээр түрүүн хэлсэн Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлийн, төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийг зүйл бүрээр хэлэлцэнэ. 39.11-д гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно. 39.12-т гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байна. Нэмэлт асуух бол 2 минут илүүгүй байна. Хариулт тайлбар хангалтгүй бол тухайн гэж үзвэл гишүүн 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асууж, тайлбар авч болно. Асуулт асууж, хариулт авах дэгийг хуульчилсан байгаа. Зүйл бүрээр хэлэлцэхэд.

**Ц.Даваасүрэн:** Ингэж явах юм байна шүү, одоо ингээд манай гишүүд ч гэсэн анхаараарай. Энэ шал өөр юм орж ирж байгаа байхгүй юу. Одоо ингээд би байна шүү дээ Монгол Улсын нэгдсэн төсвийн 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25, 26 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байвал нэрээ

өгье. Саналтай гишүүн байна уу? Үгүй ээ яах вэ ингээд нэр өгвөл тэгээд л яриад л яваад байна. Үгүй ээ тэгж хэзээ хэлэлцэж байсан юм бэ энэ чинь, тэгдээгүй байсан байхгүй юу даа. Балай юм яриад байх юм хүн хэлээд байхад чинь. Үгүй ээ одоо ингээд нэг хуулийг ийм сунжирч хэлэлцдэг болох гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ үгүй даргын биш ээ, үгүй үгүй та нар энэ. Яах вэ одоо тэгээд л явцаагай. Тэгээд л нэрээ өгвөл нэрээ өгөөд л тэгээд л яваад байна шүү.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд, зүйл бүрээр баталдаг байсан байхгүй юу та нар эндүүрээд байх юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Саналтай гишүүн байна уу? Алга байна. Аль дээр нь юм бэ? Энэ чинь ерөөсөө миний мэдэхгүй дэг болчихоод байна даа, тэгээд л тэрүүгээр нь л явъя даа. Ингэх юм байна энэ чинь ерөөсөө зүйл бүрээр явах юм байна. Ингээд түрүүн би нөгөө нэг Монгол Улсын нэгдсэн төсвийн төсвийн хүрээний 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн хүрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтаа оруулан санал асуусан шүү дээ. Ингээд та нар саналгүй байсан, асуулт асуух байхгүй байсан.

Одоо энэ дээр зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулах юм байна. Нөгөө хуучин бол ингээд зарчмын зөрүүтэй санал чинь нэг явдаг байсан шүү дээ. Одоо үгүй юм байна. Нөгөө нэг яг тухайн зүйл бүр дээрээ явах юм байна шүү. Тэгж ойлголоо тийм ээ, зүйл бүр дээрээ явах юм байна. Хуучин нөгөө нэг уншаад явдаг байсан нь үгүй юм байна. Уначих гээд байна уу? Хүлээгээдэхье тэгвэл. Манай Байнгын хорооны гишүүдийн бүртгүүлсэн ирц энд байгаа гишүүдийн юу санал хураалт явуулах боломжгүй болчихсон байна шүү. Гишүүд орж ирье. Манай байгаа гишүүд

гараа өргө дөө. Болчих юм биш үү. Ирчихсэн үү? Манай зөвлөх хаачив?

Ингээд нөгөө зүйл бүрээр хэлэлцэж байгаа учраас 1 дүгээр зүйлтэй холбогдолтой зарчмын зөрүүтэй саналын томъёолуудыг бас хурааа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 3 дахь заалтын “орлогын хэмжээ” гэснийг “орлогын доод хэмжээ” гэж, 9 дэх заалтын “санхүүжүүлэх зардлын дээд хэмжээ” хуваарилах зардлын “зардлын нийт хэмжээ” гэснийг “хуваарилах зардлын дээд хэмжээ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Д.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн цаашид ажлын хэсэг гэх. Энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Ингээд саяын санал хуралдаанд оролцсон 17-гоос 10 гишүүн дэмжигдээд дэмжээд 58,8 хувиар дэмжигдсэн байна. Юу гэнэ вэ 2 санал гэнэ үү?

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр дахиад санал хураах юм байна. Энэ чинь зүйл бүрээр нь зарчмын зөрүүтэй саналыг хураах юм байна. Тийм учраас 1 дүгээр зүйл дээр гарсан зарчмын зөрүүтэй саналыг хураана. Дараа нь 2 дугаар зүйлийг хэлэлцэхээр 2 дугаар зүйлтэй холбогдолтой гарсан зарчмын зүйлийн саналыг хураана гэж явах юм байна. Тэрнээс биш хуучин бид нар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гээд л тэгээд л уншаад явчихдаг байсан нь үгүй болчихож байгаа юм байна. Тийм

учраас нэг жсоохон будилаан гарах юм байна. Яагаад гэвэл би зарчмын зөрүүтэй ажлын хэсгээс гарсан саналын томъёоллыг нөгөө зүйл бүр нь хэлэлцэгдэхээр нь хураагаад яваад байх юм байна шүү. Тэрнээс биш нөгөө хуучин шиг уншаад явчихдаг байсан нь биш юм байна. Хойш нь тавиад яваад байх юм байна шүү. Тийм юм байгаагүй байхгүй юу. Чи зүүдлээд байх юм зүгээр.

Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 4 дэх заалт буюу “Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ” 2025 онд энийг тоогоор нь унших юм уу, тэрбум гэдгээр нь унших юм уу, их наяд гэдгээр нь унших юм уу 32 гэдгийг? “32,992.0” гэснийг “31,901.6” гэж, 2026 онд “35,849.5” гэснийг “34,967.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “34.7” гэснийг “33.6” гэж, 2026 онд “34.2” гэснийг “33.4” гэж, үзүүлэлтийн 5 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл” 2025 онд “-2,990.7” гэснийг “-1,900.3” гэж, 2026 онд “-2,975.9” гэснийг “-2,094.1” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “-3.1” гэснийг “-2.0” гэж, 2026 онд “-2.8” гэснийг “-2.0” гэж, үзүүлэлтийн 6 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ” 2025 онд “28,101.0” гэснийг “27,010.6” гэж, 2026 онд “30,779.5” гэснийг “29,897.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “29.6” гэснийг “28.4” гэж, 2026 онд “29.4” гэснийг “28.6” гэж, үзүүлэлтийн 7 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл” 2025 онд “1,900.3” гэснийг “2,990.7” гэж, 2026 онд “2,094.1” гэснийг “2,975.9” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “2.0” гэснийг “3.1” гэж, 2026 онд “2.0” гэснийг “2.8” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Болохгүй болчихно, саяын саналд 17 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар энэ санал дэмжигдсэн байна.

2 дугаар хэсэг дээр ахиад 2 дугаар хэсэг рүү оръё. Хэсэг хэсгээр нь явах юм байна. 2 дугаар хэсгээ өгчих. 1 дүгээр саяын 1 дүгээр хэсэг дээр бас АН-аас санал ирсэн юм. Бас энийг явуулах юм байна. Тэгээд хэсэг бүр дээр нь санал явдаг болохоос биш нөгөө нэг биш юм байна. АН-аас ийм санал ирүүлжээ. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагыг нэмэгдүүлэхгүйгээр баталсан дүнд багтаан тодотгол хийх гэсэн ийм санал ирүүлжээ. Яах юм бэ тэгээд? Энэ саналтай асуулт асуух уу, үг хэлэх үү? Үгүй ээ энэ чинь нэг бүрчлэн гэхээр чинь тэгнэ биз дээ? Энийг яах юм тэгээд, тэгээд хураахгүй юм уу? Юу гэж хэлж протоколдох юм бэ? Тэгээд хураалгахыг нь яах юм бэ? Энэ чинь тэгэхдээ түрүүний саналтай хамаарахгүй болчихоод байна шүү дээ. Энэ чинь тодотгол хий, багтаасан дүнд багтаан тодотгол хийх гээд байгаа байхгүй юу. Харин тийм, би тэгээд, тэгвэл бид нар сая өөрчилчихсөн учраас энэ саналыг хураах шаардлагагүй гэж үзэх юм байна шүү. Тийм. Тэгээд нөгөө нэг энэ нь зөрчилтэй санал байгаа учраас энийг хураах боломжгүй юм байна. Тийм. Ажлын хэсгийн санал дэмжигдсэн учраас АН-ын бүлгийн энэ саналыг бол 4 дүгээр саналыг хураах боломжгүй.

Энэ нь дараагийн зүйл хэлэлцэхээр хэлэлцэгдэх юм байна. Наадах чинь будилж мэдэх юм байна шүү. Дараагийн зүйл нь. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Саналтай гишүүн байна уу? Асуулт асуух, санал хэлэх гишүүн алга. Энэ дээр зарчмын зөрүүтэй санал байна уу? Энэ дээр зарчмын зөрүүтэй санал байхгүй юм байна.

3 дахь зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Нэрээ өгье. Асуух асуулттай гишүүн алга байна. Саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн алга байна. Зарчмын зөрүүтэй санал байна уу? Зарчмын зөрүүтэй, байхгүй юм уу? Одоо ингэх юм байна. Би төсвийн, үгүй ээ тийм биш ээ Батжаргалаа энэ чинь шал шинэ юм болчихоод байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлээр асуулттай гишүүн байна уу? Тогтвортой хуулийн шүү. Тогтвортой байдлын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлээр асуух асуулттай гишүүн байна уу? Асуух асуулттай гишүүн алга. Саналтай гишүүн байна уу? Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 2 дугаар зүйл, чи байж бай л даа. 2 дугаар зүйлээр асуух асуулт, саналтай гишүүн алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлээр асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Саналтай гишүүн байна уу? Алга байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлээр асуух асуулттай, саналтай гишүүн байхгүй байна.

4 дүгээр зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлээр асуух асуулттай гишүүн байвал нэрээ өгье. Алга байна. Саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлээр асуух асуулттай гишүүн байвал нэрээ өгье. Алга байна. Саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн алга байна. Одоо яах юм бэ? Ажлын хэсгийн гээд би түрүүн нөгөө нэг Тогтвортой байдлын хуулийн 2 санал хураалгачихсан шүү дээ. Тэрийг энэ дээр нь хураалгах байсан юм байна. Одоо

нөгөө зүйл, заалт бүр дээр нь хураалгах юм байна. Тэрнээс биш нөгөө хуучин шиг зарчмын зөрүүтэй саналын томъёолол гээд нэг хураалгахгүй юм байна. Одоо ингээд, аваад ир.

Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй, 1 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж эхэлье гэх юм байна. Энэ чинь нөгөө хэлэлцэх учраас. Хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байна уу? Байхгүй билүү? Ажлын хэсэг дээр байхгүй юу? Зарчмын зөрүүтэй санал алга юм байна.

Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн нэрээ өгье. Алга байна. 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байвал нэрээ өгье. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна. Алга биз дээ, өр дээр байхгүй тийм ээ? Дараагийнх нь хэд юм бэ? 2 мянга, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж, санал хураалт явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн хэн унших вэ? Аубакир унших уу? Аубакир гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн

тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгүүдийг хэлэлцэж дууслаа.

Дараагийнхаа, дараа нь тэгээд дагасан хуулийг чинь яг хууль бүрээр хэлэлцэхээр их л удах юм байна даа 15 хууль, хэдэн зүйл байгааг би бол мэдэхгүй байна. 70-аад зүйл байгаа байх. Тэгээд асуулт асуугаад байвал тэгээд л ёстой өнгөрнө шүү дээ. Одоо тэгж хэлэлцдэг болчихож байгаа юм байна шүү дээ. Явуулъя 2 дахь асуудал.

20.27 цаг

**Хоёр. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

2 дугаар асуудалдаа оръё. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулиудын төслүүдийг хэлэлцэж эхэлье. Энэ хуулиудтай холбогдолтой ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг би та бүхэнд танилцуулсан байгаа. Хаана байгаа юм бэ? Сангийн сайд танилцуулга унших юм байна шүү. Дэгийн тухай хуулийн 71.2-т заасны дагуу санхүүгийн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгүүд хуралдаанд танилцуулга хийж болно гэж заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн төсвийн төслийн талаар танилцуулга хийе. Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр ийнхүү хэлэлцүүлж байна.

Хурдтай хөгжлийн төлөөх зориг хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 онд төсвийн тодотголын төслийг боловсрууллаа. Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, эдийн засгийн өсөлтийг 5-аас 6 ба түүнээс дээш хувьд, инфляцыг нэг оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд 1 дүгээрт Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Нийслэлийн Их, бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх Монгол буюу Go Mongolia ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр, захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог авто замын төсөл, Шинэ Хархорум төсөл, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг ЗГ-ын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ, зураг

төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй бүсчилсэн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотголд тусгалаа.

3 дугаарт 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ, тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах, хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

4 дүгээрт Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар ЗГ-ын бүтцийн тухай, ЗГ-ын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

5 дугаарт эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон. Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой

харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав Аудитын дүгнэлт танилцуулъя.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ үдшийн мэндийг өргөн дэвшүүлъя. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр Монгол Улсын ЗГ шинэчлэн байгуулагдаж, ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас хурдтай хөгжлийн төлөөх зориг гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага, Монгол Улсын ЗГХЭГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

ЗГ-аас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн эрхлэн захирагчдын төсвийн зардалд 1 их наяд 116,5 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна. Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Загджав даргад баярлалаа. Дараа нь Зарлагын хяналтын дэд хорооныхыг сонсох уу. А үсгээсээ эхлэх ёстой гэнэ. Аж үйлдвэржилтийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэн танилцуулахаар байна вэ? Үүрийнтуяа гишүүн танилцуулъя. Тэгж болохоор байгаа юм уу, болохгүй байгаа юм уу? Тэгвэл тэгээд горимын санал гаргая л даа тэгвэл тэгье, гарга Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бусад Байнгын хороодоор улсын төсвийн 2024 оны хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэгдээд санал, дүгнэлтүүд нь ирчихсэн, бүх гишүүдэд тарчихлаа. Дээр нь зарчмын зөрүүтэй саналууд бүгд томъёологдоод ирчихсэн байгаа. Тийм учраас бусад Байнгын хороод, дэд хорооны санал, дүгнэлтийг уншсанаар тооцоод, тэгээд зарчмын зөрүүтэй саналууд дээрээ санал хураалт хийгээд явчихвал зүйтэй байна. Ингээж шийдэж өгнө үү гэж хүсэж байна.

**Ц.Даваасүрэн:** Дараа нь нөгөө гурилдсан байна гээд байвал бас хэцүү шүү дээ. Тэгэхдээ юу шүү энэ тусгай дэгээр явж байгаа шүү төсвийн. Төсвийн хууль чинь нөгөө тусгай дэгээр явж байгаа шүү дээ. Тэгээд бусдыг нь болохоор тусгай дэгээр явж байгаа гэххэд л ингээд байгаа юм байна. Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн, одоо жишээлбэл сая болбол тэгвэл горимын санал гаргаад л нэг бүрчлэн зүйл нэг бүрээр хэлэлцэж болохгүй гээд л горим санал гаргаад л явж болчих л байсан юм байна шүү дээ би хэрвээ тэгэх байсан юм бол. Үгүй ээ тэгээд яагаад болдоггүй юм бэ? Ингээд горимын санал гаргаад л өөрчлөөд л байдаг юм бол тэгээд л явна



шүү дээ. Энэ дээр ингэчихсэн байгаа байхгүй юу нам, эвслийн бүлэг танилцуулна гэхихсэн байгаа юм. Тэгээд Байнгын хороонд танилцуулна гэхихсэн байгаа юм. Тэгэхээр манай гишүүн танилцуулахгүй гэдэг горимын санал гаргачихъя гээд байгаа байхгүй юу. Үгүй ээ үгүй. Тэгэхээр би ч гэсэн түрүүн жишээлбэл зүйл нэг үгээр хэлэлцүүлэхгүй гэдэг горимын санал гаргавал болох л юм байна л даа одоогийн үүгээр бол. Тийм.

Улсын Их Хурлын гишүүнээс хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гэж байна. Тэгээд дараалал би тэгж болох л байсан байхгүй юу. Дараалал, журмын талаар саналыг гаргахыг горимын санал гээд байгаа юм байна л даа. Үгүй ээ ялгаагүй л байхгүй юу даа, хэлэлцэх дараалал байхгүй юу. Үгүй ээ үгүй одоо ингээд байна л даа. Та нар саналыг ойлгосон байх. Нөгөө Байнгын хороодын гаргасан дүгнэлтийг дэг дээр болбол танилцуулна гэхихсэн байгаа. Гишүүн горимын санал гаргаад танилцуулахгүй явъя гээд байгаа юм. Тэгээд яах вэ дээ тэгээд тэгж хурааж болдог юм бол тэгээд л явъя. Үнэн юм байгаа биз? Ингээд дур дураараа дэг тогтоод байна шүү, ингэж болохгүй шүү. Би түрүүн тэгвэл тэгээд хураалгачхаж болох л байсан байхгүй юу. Хэлэлцэх дараалал гээд тэгвэл ингэж явахаа больё гээд л. Хаана тийм юм байгаа юм бэ? Үгүй ээ үгүй тэгвэл түрүүний тэр бүх асуудал чинь цаасаар ирчихсэн байгаа байхгүй юу. Үгүй ээ үгүй одоо энэ танилцуулгатай чинь холбогдуулаад асуулт хасах эрх бас байгаа байхгүй юу даа. Та юу асуухыг нь бас мэдэхгүй шүү дээ. Асуухгүй гэдгийг нь яаж мэдээд байгаа юм бэ.

Энэ тэгэхдээ юу байх ингэж ч арай болохгүй байх, танилцуулна гэхихсэн байхад нь горим гаргаад л танилцуулахгүй гээд л дэгээ өөрчлөөд л ингээд яваад байж болохгүй байх. Тэгвэл ерөөсөө бүх дэгээ тэгээд горимын саналаар хар даа ингэчихсэн байгаа

байхгүй юу. Энэ хэлэлцэх дараалал гэж байгаа шүү дээ түрүүний миний нөгөө хэлэлцэх дараалал хэлэлцэх эсэх талаар бол горимын санал гаргаж болно гээд байгаа байхгүй юу Манай хуулийнхан энэ танилцуулна гэснийг танилцуулахгүйгээр явчихъя гэж горимын санал гаргаж байна. Энэ болох юм уу, горимын саналыг хураалгах боломжтой байна уу? 6 дугаар микрофоныг өгье.

**Ч.Дондогмаа:** Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлын болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг хэлнэ гэж байгаа юм. Тэгэхээр хэлэлцэх журамтай холбогдуулж байгаа гаргасан санал гэдэг горимын саналд хамаарахаар байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл хууль давсан горимын санал гаргаж болохгүй учраас нөгөө танилцуулдгаараа явъя. Үүрийнтуяа гишүүн танилцуулгаа хийе.

**Д.Үүрийнтуяа:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засгийн.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** 13.2-ын дагуу би горимын санал хураалт явуулахыг хориглох юм байна. Тийм учраас би боломжгүй байна. Үүрийнтуяа гишүүн танилцуулаад явъя.

**Д.Үүрийнтуяа:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16, 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороод

Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ. Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан 2024 оны төсвийн тодотголын төсөлд тусгагдсан хоршооны гишүүн малчинд олгох хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн татаас болон зээлийн хүүгийн үйлчилгээний зардлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө биелэгдэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар төсвийн тогтворжуулалтын болон үндэсний баялгийн сангийн үлдэгдлийн талаар асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулъя. Энхбаяр гишүүн. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их

Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэхээр шийдвэрлэж, төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар хиймэл дагуул үндэсний аюулгүй байдалд онц чухал шаардлагатайг дэмжиж байгаа бөгөөд энэ зардалд хөөргөлтийн өртөг туссан эсэх, энэ хиймэл дагуул нь онцгой байдал, батлан хамгаалах салбарт гамшигийн болон онцгой байдлын үед чухал хэрэгцээтэй учир нууцлалын болон кибер аюулгүй байдлын хяналтыг нь тогтоож төсөвт тусгасан эсэх, цаашид хяналтад анхаарах, 2025-аас 2028 оны төсөвт кибер аюулгүй байдлын төсвийг тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн ТЭЗҮ, зураг, төсөв, төсөл, арга хэмжээг 60 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр нэмж тусгасантай холбоотойгоор үлдсэн 4 сарын хугацаанд энэ ажлыг бүрэн гүйцэтгэх боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар гүйцэтгэх чиг үүрэгтэй байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, хөрөнгө санхүүжилтийг сайжруулах, ажилгүйдэл, ядуурлын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг

сайжруулж анхаарч ажиллах талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төсөв, санхүүгийн аюулгүй байдал чухал бөгөөд төсвийн тэлэлт зардал нэмэгдэхтэй холбогдуулан үүсэх эрсдэлээс болгоомжлох, төсвийн зарлага, орлого батлагдсанаасаа хэр хэмжээтэй нэмэгдэх, төсвийн зарлага ирэх 3 жилийн хугацаанд хэр хэмжээгээр өсөх талаар асуулт асууж, төсөвт үүсэх эрсдэлийг тооцох, өрийн эзлэх хувийг шат дараатай бууруулах, төсвийн сахилга батыг хангах, гадаад зээлийн эргэн төлөлтийн асуудалд анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудын ажилтан, албан хаагчдын цалин, хангамжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Батбаатар нар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо зээлийн гэрээ хэлэлцээрүүдийг хэлэлцэж баталдаг, уг зээлүүдийн зориулалт, зарцуулалт, үр ашигтай холбоотой асуудалд анхаарч, өрийн асуудлаар тусгайлан хурал сонсгол зохион байгуулах нь зүйтэй талаар үг хэллээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг

хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр гишүүнд баярлалаа. БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа танилцуулна. Пунсалмаа гишүүн. Тийм үү, тэгье.

**Б.Пунсалмаа:** Инновац, Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний Баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн Улсын Их Хуралд яаралтай горимоор хэлэлцүүлэн шийдвэрлэж, төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 24 оны 8 дугаар сарын 16, 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

Инновац, цахим бодлогын хороо 2024 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад багтсан татаасыг ямар арга хэмжээнд зарцуулдаг талаар, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамрах ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат төсөл, арга хэмжээний төсөвт өртөг

санхүүжүүлэх дүн, хэрэгжих хугацаанд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжүүлэх байршил сумдын тоог цөөрүүлж, Хэнтий аймгийн Батноров, Дадал, Баян-Адарга, Галиар, Биндэр, Баянмөнх, Дархан, Норовлин 8 сумдад үүрэн холбооны сүлжээ оруулах зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.6 дахь хэсэгт заасны дагуу санал хураалтууд явуулж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт, дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Пунсалмаа гишүүнд баярлалаа. БСШУС-ын байнгын хорооны саналыг Улсын Их Хурлын гишүүн Дамдинням гишүүнд танилцуулна. Дамдинням гишүүн чөлөө авчихсан байгаа учраас би танилцуулчихъя.

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурал яаралтай горимд

хэлэлцэхээр шийдвэрлэж, төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын, Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

БСШУС-ын Байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хөдөө орон нутгийн ЕБС-ийн багш, ажилтны нийгмийн баталгааг хангахаар зохицуулсан Боловсролын ерөнхий хуулийн заалтууд хэрэгжиж байгаа эсэх, жирэмсний амралтыг ажилласан жилээр тооцож байгаа эсэх, ерөнхий боловсролын сурагчдын боловсролын чанарын үнэлгээний шалгалт болон PISA-гийн үр дүнгээр хийх үйл ажиллагааны төлөвлөгөө төсвийн төсөлд тусгах эсэх талаар, ЕБС-ийн англи хэлний багш нарын хүрэлцээг хангах тал дээр ямар арга хэмжээ авч байгаа талаар, мэргэжлийн боловсролын салбарт хөрөнгө оруулалт бага байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд туссан Хөгжлийн сангийн хөрөнгө 2025 оны төсөвт туссан эсэх талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх БСШУС-ын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Хууль зүй биш ээ, Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

**Б.Баярбаатар:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

Ёс зүй, дэгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа хуулийн төслүүд хуулийн шударга ёсны зарчимтай хэр нийцэж байгаа талаар, ямар нэгэн маргаантай байдал үүсвэл түүнийг хэлэлцэх үүргийг Ёс зүй, дэгийн байнгын хороо цаашид хүлээх эсэх талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ёс зүй, дэгийн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Баярбаатар гишүүнд баярлалаа. Түрүүн Пунсалмаа гишүүн чинь Инновац, цахим бодлогын байнгын хорооны дүгнэлтийг уншихсан юм байна шүү дээ. Энэ буруу бичихсэн юм байна. БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар танилцуулна.

**Г.Ганбаатар:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16, 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын дэд хороонд шилжүүлсэн.

БОХХАА-н Байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал ХХААХҮ-ийн сайд төсөв дотроо зохицуулалт хийх замаар Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгох зээлийн хүүгийн татаасыг шийдвэрлэх боломжтой эсэх, газар тариалан, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах үүднээс 100 мянган тонн улаан буудайг нөөцөд худалдан авах санхүүжилт төсвийн тодотголд туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Халх голын бүтээн байгуулалтын бүсийн ажлын үйл явц, байдал, отрын бүс нутгийн үйл ажиллагааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен өнгөрсөн өвлийн өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан гарсан нийт зардал, Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд газар тариалангийн салбарт олгох зээлийн дүнг нэмэгдүүлэх боломжийн талаар асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралд Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг зарчмын зөрүүтэй 1 санал оруулсныг гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүнд баярлалаа. Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баясгалан танилцуулна. Баясгалан гишүүний микрофоныг өгье.

**Ж.Баясгалан:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 сарын 16, 19-ний өдрүүдэд чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 8 сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төсөлд туссан хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийг нийгмийн нөлөөллийн үнэлгээний шаардлагуудад нийцүүлсэн эсэх, олон жил он дамнасан сургууль, цэцэрлэгийн барилгын санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат төсөлд ЭМД-ын болон нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулах, үр өгөөжтэй ажиллах асуудлыг тусгасан эсэх талаар, сум, багийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд автомашины асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их

Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь санал хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Ц.Даваасүрэн:** Баясгалан гишүүнд баярлалаа. ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна.

**Б.Баярбаатар:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэхээр шийдвэрлэж, төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын хороонд тус тус шилжүүлсэн.

ТББХ 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Ц.Даваасүрэн:** Баярбаатар гишүүнд баярлалаа. ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Заяабал гишүүн танилцуулъя.

**Б.Заяабал:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэхээр шийдвэрлэж, төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох Байнгын хороод, Зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

ХЗБХ 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллагуудын 2024 онд

хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр өмнөх жилүүдийн болон 2024 оны төсвийн зарцуулалтын явц, үйл ажиллагааны үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ХЭҮК-ын орон нутгийн албан хаагчдын нэмэгдэл болон ШЕЗ-ийн урсгал зардлын талаар, мөн хууль зүйн салбарын албан хаагчдын цалин, нийгмийн баталгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хууль зүйн салбарын төсөв төсөлд хэрхэн туссан талаар, мөн Шүүх байгуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах төсвийн талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-НАРА ХЭҮК-ын төсвийн талаар, мөн орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчдын тоног төхөөрөмж хөрөнгө оруулалтын талаар төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хууль зүй зүйн салбарын албан хаагчдын цалингийн ялгаатай байдлыг арилгахад анхаарах, шүүгчдийн ажлын ачаалал болон ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шүүхийн нэгдсэн байрны барилгын талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал ХЭҮК-ын орон нутаг дахь албан хаагчид, цагдаагийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад анхаарах, шүүхийн байрны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүдийн гүйцэтгэл дээр хяналт тавьж ажиллах талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтжаргал, Цогтбаатар зарчмын зөрүүтэй 1 саналын томъёолол гаргасан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.6 дахь хэсэгт

заасны дагуу санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Заяабал гишүүндээ баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулъя.

**Б.Мөнхсоёл:** Оройн мэнд хүргэе эрхэм гишүүд. Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэхээр шийдвэрлэж, төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16, 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан



журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал ЗГ-ын мөрийн хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийг төсвийн хөрөнгөөс гадна төрийн эзэмшлийн томоохон компаниудын ноогдол ашгаар санхүүжүүлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл болон өрийн хязгаартай нийцэхгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн хөдөөгийн хөгжлийг хэрхэн дэмжих, Зам, тээврийн сайдын багцад зүүн бүсийн Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50км хатуу хучилттай авто замын барилгын ажил болон Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 27км хатуу хучилттай авто замын барилгын ажил төслүүдийн санхүүжилт тусгагдсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан Солонго 1, 2 хороолол барих төслийн хүрээнд хорооллын дундах сургууль, цэцэрлэгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Сэлбэ дэд төвийн санхүүжилт, газар чөлөөлөлтийн асуудлын талаар, ЗГ-ын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор төслийн ТЭЗҮ бэлэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад аялал жуулчлалыг дэмжихэд зориулан хэдэн төгрөгийн санхүүжилт тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл эдийн засгийн үр өгөөжийг харгалзан зарим сумдыг нэгтгэх, нийлүүлэх талаар болон энэ асуудалд аудит хийх боломжтой эсэх, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлээс хийж байгаа ажлыг дэмжиж хамтран ажиллах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин мега төслүүд хэрэгжсэнээр авто замын

ачаалал хэрхэн буурах, намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зүйлүүд ЗГ-ын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй байгааг Үндэсний аудитын газар анхаарах талаар, Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаанаар Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж төрийн өмчийг Нийслэлд шилжүүлснээр тухайн хуулийн этгээдийн өрийн асуудал хамт шилжих эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй тодорхой санал гаргаагүй бөгөөд хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Зарлагын хяналтын дэд

хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг танилцуулна. Ганзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Ганзориг:** Энэ микрофон нь орж ирэхгүй, одоо орж ирж байна. Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэхээр шийдвэрлэж, төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороонд, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Дэд хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут төсвийн орлогын өнөөгийн нөхцөл байдал, төсвийн төсөлд орлогыг хэт өөдрөгөөр төсөөлсөн байх бөгөөд цаашид нүүрс, зэсийн үнэ тогтвортой байх эсэх, ЭМД-ын сангийн хөрөнгийн талаар, Үндэсний аудитын газар акт тавьсантай холбогдуулан эрүүл мэндийн салбарын ажилтнуудад цалин, цалингийн урамшуулал, нэмэгдэл олгох боломжгүй болсон талаар, 2024 оны төсвийн тодотголын төсөл хөтөлбөрүүдэд нийцлийн аудитын газар хийсэн, аудит хийсэн эсэх талаар, нийцлийн аудит

хийсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ-ийг боловсруулахад хийгддэг тооцоолол, нэгдсэн норм, аргачлал мөрддөг эсэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих хунсний хувьсгалын хүрээнд улаан буудайг нөөцлөх арга хэмжээнд зарцуулагдах 2024 оны төсвийн тодотголд тусгагдаагүй байгаа шалтгаан байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд төсөл, хөтөлбөрт хийгдэх ТЭЗҮ-ийн тооцоолол аргачлалын талаар, зарим шаардлагагүй төсөл, хөтөлбөрүүдийг хэмнэх, хуримтлал бүрдүүлэх боломжтой эсэх, гаднын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт дотоодын хөрөнгө оруулагчдыг хамруулах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал төсвийн тухай төсвийн тусгай шаардлагын үндсэн 4 хязгаараас 3 үзүүлэлтэд өөрчлөлт оруулахаар хуулийн төсөлд тусгасан байх тул тооцоолол төлөвлөлтийг боловсронгуй болгох талаар үг хэлсэн болно.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гарсан санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж

өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Ганзориг гишүүнд баярлалаа. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлттэй танилцлаа. Саяын эдгээр санал, дүгнэлттэй холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна.

Асуулт асуух гишүүн алга байгаа учраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулж урьдчилан бичгээр томъёолж ирүүлсэн саналуудыг хэлэлцэж эхэлье. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгээс төсвийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн байгаа. Та бүхэнд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тараасан. Эдгээр зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулж эхэлье. Энийг дараа нь биз дээ? Ажлын хэсгийн дараа.

Санал хураалт явахын өмнө Булгантуяа гишүүн, Чойжилсүрэн гишүүн нарын хуралд оролцох боломжгүй, ирцээс хасаж өгөөч гэсэн саналын дагуу бүртгэлээс Булгантуяа, Чойжилсүрэн гишүүн нарыг хасъя. Ажлын хэсэг манай техникийн ажлын хэсгийнхэн. Бичгээр өгөөгүй юм байна, биш ээ бичгээр өгөөгүй юм байна. Тэгэхээр болохгүй юм байна, харин болохгүй юм байна. Бичгээр өгөөгүй юм байна тийм ээ, юу болсон тэр нь? Чойжилсүрэн бол уг нь надад тэгж хэлсэн. Тэгэхдээ одоо тэр нь болохгүй байгаа юм биш үү? Харин тэгсэн юм. Тэгэхдээ нөгөө амаар болохгүй байгаад байгаа юм биш үү? Протокол ч хэлээгүй л дээ, энд микрофонд хэлээгүй байхгүй юу. Яах юм бэ манай хуулийнхан? Уг нь

надад бол өөрөө хэлсэн юм. Түүн дээр чинь бол нөгөө дэмжээгүйгээр гарчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр би тэгээд байж болох юм уу? Бичгээр өгнө гээд амжаагүй юм байна яах юм бэ? Манай 6 номерын микрофон.

**Ч.Дондогмаа:** Чөлөө, нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хуралдаанд чөлөө авах тохиолдолд бичгээр урьдчилан мэдэгдэнэ гэсэн зохицуулалт байгаа Дэгийн хууль дээр. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид энэ хуулийн 7.3-д заасан шалтгаан үндэслэлээ бичгээр урьдчилан мэдэгдэнэ гэсэн зохицуулалт байгаа.

**Ц.Даваасүрэн:** Саналаа ингээд, саналаа ингэсэн байхгүй юу. Би зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бүгдийг нь дэмжиж байгаа гэсэн байхгүй юу. Тэгж явж болох юм уу?

**Ч.Дондогмаа:** Гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан бол бичгээр бид өгсөн байх ёстой.

**Ц.Даваасүрэн:** Биш биш. Энэ Чойжилсүрэн чинь нөгөө ЗГ-ын гишүүн шүү дээ. Тэгэнгүүт нөгөө энэ хуулийн төсөл чинь ЗГ-аас өргөсөн учраас би энэ хуулийн төслүүд дээр хураагдаж байгаа санал дээр бүгдэд нь дэмжинэ гэхчхэн байхгүй юу. Тэгээд санал хураалт явахаар намайг дэмжсэнээр тооцоод байгаач гээд байгаа юм. Тэгтэл нөгөө дэлгэц дээр чинь бүртгүүлчихсэн учраас дэмжээгүйгээр гарчхаад байгаа шүү дээ. Тэрийг тэгж засаад байж болох юм уу?

**Ч.Дондогмаа:** Тийм зохицуулалт Дэгийн хууль дээр бол байхгүй. Тийм зохицуулалт Дэгийн хууль дээр байхгүй. Гишүүн ирцтэй оролцох ёстой. Оролцоогүй тохиолдолд бас.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл боломжгүй юм байна. Тэгвэл Чойжилсүрэн гишүүн, Булгантуяа гишүүнийг, харин тийм. Тийм учраас ирцээс өөрсдийнх нь хүсэлтийн дагуу хасчихъя. Тэр өөрсдийнх нь хэлсний дагуу ирцээс хасаж болох юм уу, хүсэлтийнх нь дагуу, техникийн тийм боломж байгаа юу?

**Ч.Дондогмаа:** Гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан буюу картаа сугалсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулан тухайн асуудлаар санал.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ үгүй чөлөө авсан, чөлөө авсан.

**Ч.Дондогмаа:** Тэгэхээр санал, чөлөө авсан тохиолдолд эсрэг санал өгсөнд тооцохгүй гэдэг юутай зохицуулалттай.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл тэгэхдээ түүн дээр нөгөө эсрэгээр гараад байгаа шүү дээ. Чөлөө авсан хоёулаа. Тэгэхээр яах юм бэ? Энд чинь тийм зохицуулалтгүй болчихоод байна шүү дээ. Чөлөө авчихсан болбол яах юм бэ гэдэг нь байхгүй болчихоод байна шүү дээ. Тэгэхээр чөлөө аваад, өөрсдөө хүсэлт гаргаж байгаа учраас тэндээс хасчхаж болох юм уу? Чөлөө авчихсан тохиолдолд болбол ирцэд оруулахгүй гэж зохицуулагдаж байгаа байхгүй юу үүгээр. Тэгэхээр ирцээс тэр 2 гишүүнийг чөлөө авсан учраас хасаад өгөөч. Үгүй ээ үгүй болохгүй байна, болохгүй байна, болохгүй байгаад байна. Тэнд чинь эсрэгээр гарчхаад байгаа учраас. Нөгөө бичгээр өгөөд, ингээд тэгээд гэж юм байхгүй юм байна л даа. 2 гишүүн чөлөө авсан яах юм бэ тэр зохицуулалтыг нь хийе. ... гээд ойлгогчхож болдоггүй, үгүй ээ бас хэцүү юм даа. Одоо нөгөө чөлөө авсан болохоор дэмжсэнээр тооцно гэж, үгүй ээ чөлөө аваагүй бол дэмжээгүйгээр тооцох юм байна. Тэгэхээр эсрэгээрээ чөлөө авсан

юм чинь дэмжсэнээр тооцоод явчхаж болох уу?

Надад бол байна шүү дээ хоёулаа амаар чөлөө авлаа, бид энэ ЗГ-аас оруулсан хуулийн төслийг дэмжиж байгаа гэсэн ийм үгээ хэлээд чөлөө авцаасан. Тэгэхээр хар даа, өөрөө албан ёсоор чөлөө аваад явсан бол яах вэ гэдэг зохицуулалт байхгүй байна шүү дээ. Тэгэхээр өөрөө чөлөө аваад, хуралдааныг дэмжиж байгаа саналаа илэрхийлээд явсан учраас болбол миний бодлоор болбол дэмжсэнд тооцоод явах бүрэн бололцоотой л байна даа. Тэрний оронд харин та нар нэгэнт ингээд юу өөрсдөө хэлээд байгаа юм чинь ирцээс нь хасчихмаар байгаа байхгүй юу. Үгүй ээ үгүй юу болохгүй бол хасчхаарай гэсэн юм. Болж байвал миний саналыг дэмжсэнээр аваарай гэсэн байхгүй юу. Яагаад гэвэл ЗГ-ын гишүүн эсрэг санал өгч болохгүй гэж өөрөө тэгсэн байхгүй юу.

Яах вэ сая өнгөрсөн хавар нөгөө энэ сая Дэгийн хуульд чинь их том өөрчлөлт орчихсон байхгүй юу. Нөгөө пропорциональ ороод ирчихсэн, 126 гишүүн болсон болохоор нөгөө нэг үг, зөвшөөрөл авч хэлдэг энэ тэр гээд. Тэгээд энэ хүрээнд бол нэлээн том өөрчлөлтүүд явчихсан учраас жоохон Дэгийн хууль дээр болбол асуудлууд байна. Одоо ингээд энэний эсрэг утгаар нь ойлговол чөлөө авсан учраас ирцээс хасах ёстой болчихоод байгаа байхгүй юу. Тэгж байж нөгөө эсрэг санал өгөөгүйд тооцогдоно шүү дээ. Ийм нэг хувилбар байгаа юм байна. Ингээд хэдүүлээ ингээд системийг чөлөөлөөд, шинээр бүртгүүлээд явчихвал тэр 2 хасагдаад явчих юм байна. Одоо байгаа гишүүд. Тэгэхгүй бол тэр хоёрын тэнд эсрэгээр гарч байгааг тооцож болохгүй юм байна. Эртээд нөгөө та бол яах вэ өөрөө байгаад протоколдоод байсан учраас болоод байсан байхгүй юу. Өөрсдөө байхгүй учраас протоколгүй учраас тэмдэглэж болохгүй болчихоод байгаа юм байна.

Гишүүд ээ нэлээн олон санал хураалт байгаа шүү. Хэдүүлээ яахгүй бол. Тэгээд дараа нь нөгөө дагасан 15 хуулийг нөгөө зүйл нэг бүрээр явах учраас нэлээн удаан цаг авна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулж, санал хураалт явуулъя.

Нэг.Төсвийн ерөнхийлөн захирч хооронд зардал шилжүүлэх санал.

1.Сангийн сайдын төсвийн багцын эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгогдох санхүүжилтийг 34.5 тэрбум төгрөгөөр бууруулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын орон сууцжуулалтад тусгагдсан санхүүжилтийг мөн дүнгээр нэмэгдүүлэх.Эдний сайдад, ийм нэртэй байгаа юм уу? Багад нь шилжүүлэгдчихэж болдоггүй юм уу? Яг тийм зориулалт байгаа юм уу? Байхгүй шүү дээ. Барилгын багад тийм. Яг ийм зориулалт байхгүй шүү дээ. Орон сууц ... санхүүжилт. Байдаггүй юу? Ирц байхгүй, яах вэ өөрсдөө л удна шүү дээ. Алдаатай юм хэдүүлээ хийж болохгүй шүү дээ. Зардлын зүйл ангийг нь зааж өгөхгүй, 34 тэрбумыг шууд шилжүүлчих гээд байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө зардлын зүйл ангийг нь зааж өгөхгүй бол болохгүй л дээ, юунд зарцуулах гээд байгааг нь. Дараа нь 34-ийг юунд ч хэрэглэхэж болохоор болчихоод байгаа байхгүй юу.

Гишүүдийг оруулчихъя, одоо санал хураалт явуулъя. Үгүй ээ үгүй одоо санал хураана. Болохгүй, болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Дээгээрээ болохгүй болчихоод байна. Хэдхэн санал юм байна даа, 10-хан санал юм байна, гялалзуулъя. Дараа нь бол яах вэ нөгөө дагасан 15 хуулийг чинь нөгөө зүйл бүрээр хэлэлцэхээр аягүй удна хэдүүлээ. Бүхэлдэж болохооргүй болчихсон юм

байна. Хуучин бол зүгээр ингээд л хуулийн төсөл дээр санал, юу асуулт байна уу гээд л явчихдаг байсан байхгүй юу. Одоо болохоор нөгөө зүйл бүрээр нь явах юм байна. Энэ ёстой ажлын хэсэг дээр орж ирээгүй юм байна шүү уучлаарай. Энийг ёстой орж чадахгүй шүү. Ямар Байнгын хороо юм бэ? ХЗБХ-ны санал явах юм байна лээ.

Гишүүд ээ хуралдаанаа үргэлжлүүлъя. Манай Байнгын хорооны гишүүд орж ирээд, санал хураалт явуулъя. Шуурхайлъя. Ингээд Тэмүүлэн гишүүн ороод ирэхээр 8, 9 болчихож байгаа учраас эхэлье. Хэнийгээ? Батбаярыг дуудчихъя аравхан. 10-хан санал юм байна. 10-хан санал гялалзуулъя. Тийм дуусахгүй, дуусахгүй. Эхний саналыг хэдүүлээ хураая. Нэг дэх санал болбол төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зардал шилжүүлэх санал байна.

Сангийн сайдын төсвийн багцын эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгогдох санхүүжилтийг 34.5 тэрбум төгрөгөөр бууруулж, орон сууцны санхүүжилтийн зориулалтаар гэж оруулж өгөхгүй бол болохгүй байна, зориулалтаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын төсвийн багцыг мөн дүнгээр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн цаашид ажлын хэсэг гэх. Хэдүүлээ санал хураалт явъя. Одоо нэг 2 гишүүн ороод ирвэл болох гээд байна тийм ээ. Тэмүүлэн гишүүн одоо ороод ирнэ. Тэгээд хураагаад үзье. Тэмүүлэн ороод ирнэ. Үгүй ээ яах вэ Тэмүүлэнг ороод ирэхээр хураагаад үзье. 7 хүрэхгүй. Тэмүүлэн ороод ирэхээр 8 болно тэгэж байж хүрэх байхгүй юу. 8 болохоор хүрэхгүй. Тэмүүлэн, Батбаяр ороод ирэхээр хүрнэ. Тэгээд хэдүүлээ хураагаад явчихъя. Батлут явчхаж байгаа юм байна, явна.

Гишүүд ээ, хураая. Та хэд арай ч эсрэг өгөхгүй байгаа юм байгаа биз, өгөхгүй юм байгаа биз дээ? Хураая. 1 дэх саналаар дэмжье гэж сая би танилцуулсан. Энэ 1 дэх саналыг зардал шилжүүлэх тухай саналыг гишүүдээ анхааралтай байгаарай. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зардал шилжүүлэх тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна.

2 дахь санал. Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал. 1.Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томъёоллын 1 дүгээр хавсралтад тусгагдсаны дагуу нийт 31 их наяд 314,7, 31 тэрбум байх тийм ээ, уучлаарай, 31,314.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 13,907.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг хасах, 2024 онд 44,307.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 16,833.7 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ санал дэмжигдсэнгүй. Энэ нөгөө Чойжилсүрэн, Булгантуяа 2 хасагдахгүй болохоор яг ингэнэ л дээ. Яах юм бэ, чи санал гаргачихна шүү дээ. Дагасан. Тэгээд тэр нь зөрчилтэй болчихоод байх шиг байна золиг чинь. Үгүй ээ, нөхөд өө ийм хар даа.

Одоо энэний чинь дараа бид нар 15 дагах хууль хэлэлцэнэ. Дагах хуулийг шинэ Дэгийн хуулиар зүйл нэг бүрээр хэлэлцэнэ. Асуулт асуугаад байх юм бол бүр мөдгүй юм болно. Тийм учраас маргааш хэрвээ яг ингэнэ гэх юм болбол нөгөө хугацаандаа бид нар чинь энэ

төсвийн тодотголыг хэлэлцэж амжихгүй болчих гээд байна шүү дээ. Тийм. Мөнхсоёл гишүүн горимын санал гаргая. Энэ 10-хан санал юм байна лээ.

**Б.Мөнхсоёл:** Дарж амжаагүй байгаа болохоор саяын юуг санал хураалтыг дахиж явуулъя, хүчингүй болгож өгнө үү.

**Ц.Даваасүрэн:** Хүчингүй болгож өгөөч гэдэг санал уу? Мөнхсоёл гишүүний гаргасан саяын саналыг хүчингүй болгоё гэсэн горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Тэгье. Батжаргал гишүүний, Батжаргал микрофондоо хэлчих. Батжаргал гишүүн. Үгүй ээ тэгэхдээ нөгөө нэг.

**Ж.Батжаргал:** Би сая дэмжиж санал өгсөн юм. Тэгээд уншигдахгүй байна. Тийм учраас намайг дэмжсэнээр протоколд авчихъя.

**Ц.Даваасүрэн:** 17-гоос 9 дэмжсэн учраас энэ санал дэмжигдсэн байна.

3 дахь санал, 2 дахь санал. Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томъёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсаны дагуу 21,886.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 17,317.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл, арга хэмжээг нэмж, 124,488.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 18,055.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 13,423.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хавсралтад тусгагдсаны дагуу 3,566.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ 2 дахь санал 17-гоос 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Түрүүний нэг дэх саналыг дахиж хураалгах юм байна. Горимын санал дэмжигдсэн тул. Батжаргал гишүүн дэмжсэн учраас горимын санал

дэмжигдсэн тул зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн, мань хүний горимын саналаар хураасан чинь хаирынх нөгөө эсрэг гарчхаад тэгээд нэмэхээр горимын санал дэмжигдчихэж байгаа байхгүй юу. Тийм дэмжигдсэн тийм. Тийм учраас харин нөгөө горимын санал дэмжигдсэн тул Мөнхсоёл гишүүний горимын санал дэмжигдсэн тул 1 дүгээр саналыг дахин хураая. Би бүүр унигъя, баараггүй дээр шүү дээ. 1.Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томьёоллын 1 дүгээр хавсралтад тусгагдсаны дагуу нийт 31,314.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 13,907.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг хасах, 2024 онд 44,307.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг 16,833.7 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэдгээр дахин хураая. Саналыг хуралд оролцсон 17 гишүүнээс 9 дэмжиж, 52,9 хувийн саналаар дэмжигдсэн байна.

**3 дахь санал.** Төслийн 2 дугаар хавсралтаас саналын томьёоллын 3 дугаар хавсралтад тусгагдсаны дагуу дүнд өөрчлөлт оруулахгүйгээр 5 төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршлыг өөрчилж, 1 төсөл, арга хэмжээний ерөнхийлөн захирагчийг тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 10, Батжаргал гишүүн микрофондоо протоколд оруулъя.

**Ж.Батжаргал:** Би саяын санал хураалтыг дэмжиж санал өгсөн, уншигдсангүй. Тийм учраас намайг нэмж дэмжсэнээр протоколд авна уу.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүний дэмжсэн саналыг тооцоод, 17 гишүүнээс 9 гишүүн дэмжсэн тул уг санал дэмжигдлээ.

Гурав.Төслийн 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах санал.

1.Хавсралтын 10.1.1.1 дэх дэд заалтын “санхүүгийн” гэсний дараа “тайлангийн” гэж, 28.2.4.3 дахь дэд заалтын “суралцагч” гэсний өмнө “сургуулийн” гэж, 28.4.2.2 дахь дэд заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж тус тус нэмж нэмэх, нэмж, хавсралтын нэрийн “захирагч нарын” гэснийг “захирагч бүрийн” гэж, 4.1.1 дэх заалтын “хэргийн эзлэх хувь” гэснийг “хэрэг” гэж, 9.1 дэх хэсгийн “сахин хамгаалах” гэснийг “хангах” гэж, 10.1.1.2 дахь дэд заалтын “Санхүү нийцлийн” гэснийг “Санхүүгийн тайлангийн” гэж, 10.1.1.3, 10.1.1.4 дэх дэд заалтын “Гүйцэтгэл нийцлийн” гэснийг “Гүйцэтгэлийн” гэж, 11.1.3.1 дэх дэд заалтын “Гомдол” гэснийг “Өргөдөл, гомдол” гэж, 12.1.1 дэх заалтын “Зохицуулалтын хүрээний салбарын” гэснийг “Зохицуулалттай” гэж, 14.1.4.1 дэх дэд заалтын “Шинэ” гэснийг “Шинээр боловсруулах” гэж, 17.1.1 дэх заалтын “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн” гэснийг “Төрийн өмчит компанийн” гэж, 21.1.1 дэх заалтын “чанарын менежментийн стандартыг хангуулна” гэснийг “стандартыг хангуулж, чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлнэ” гэж, 20.2.1.2 дахь заалтын “хийх сургалт, гаргах лавлагаа” гэснийг “сургалт, лавлагаа” гэж, 22.3.3 дахь заалтын “Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалж” гэснийг “Ус бохирдох, усны нөөц хомстохоос хамгаалж” гэж, 23.2.1.1 дэх дэд заалтын “6.0” гэснийг “5.1” гэж, 28.2.2.2 дахь дэд заалтын “хүүхэд” гэснийг “суралцагч” гэж, 33.1 дэх хэсгийн “Эрчим хүч, уул уурхайн бодлого” гэснийг “Эрчим хүчний бодлого” гэж, 35.3.1.1 дэх дэд заалтын “Аялал жуулчлалын зам дагуу” гэснийг “олон улсын, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу” гэж, 39.1.1.1 дэх дэд заалтын “журмын” гэснийг “журмаар тогтоосон” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Саналыг 17-гоос 9 гишүүн дэмжиж, 52,9

хувийн саналаар яг уг санал дэмжигдсэн байна.

Дөрөв.Бусад байнгын хороодоос гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 2 дугаар хавсралтын XI.2.3.1. “Зэвсэгт хүчний тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2024-2024, төсөвт өртөг 40,576.3 сая төгрөг, санхүүжих дүн 40,576.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,811.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн урсгал зардлыг нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар. ХЗБХ дэмжсэн санал байна. Энэ чинь нөгөө 40-ийг л юм байна даа. Ажлын хэсэг дээр бол яригдаагүй юм байна. Уг саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжигдсэн, дэмжээд уг санал дэмжигдээгүй байна.

2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц дахь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зардлыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дахь Хориооны зээл, цагаан алт хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэгийг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхулэг. БОХХАА-н байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжээгүй саналыг, уг саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 17 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй. Ер нь бол Байнгын хороон дээр гарсан саналуудыг дэмждэггүй юм даа.

3.Төслийн 2 дугаар хавсралтын 25.1.6 үүрэн холбооны сүлжээ Хэнтий, Норовлин, Баян-Овоо, Галшар, Мөрөн, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх,

Баянхутаг сум гэж төсөл, арга хэмжээний нэрийн Өмнөдэлгэр, Мөрөн, Баян-Овоо, Баянхутаг гэснийг хасах. Энэ чинь бид ажлын хэсгийн саналтай давхцаж байгаа учраас энэ саналыг хураах шаардлагагүй. Ажлын хэсэг дээр нөгөө хавсралтаар хураагдчихсан санал.

Тав.Зарчмын зөрүүтэй саналын томъёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал. 1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, ангилал, төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эилэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ зайлиггүй хийгдэх ёстой. 17 гишүүн санал хураалтад орж, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар дэмжигдсэн байна. Болчихсон, болчихсон, дэмжигдчихсэн. Мөнхсоёлоо зүгээр. Чи тэгвэл протоколд зүгээр яачих. Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

**Б.Мөнхсоёл:** Цаанаас нь уу? Сая аягүй чухал асуудал харин ч ёстой нэг дэмжмээр байсан юман дээрээ энэ машин тоног төхөөрөмж ажиллаагүй учраас дэмжсэн гэдгээр миний саналыг авна уу. Татгалзаагүй шүү.

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүний саналыг дэмжсэн гэдгээр авъя. Зургаа.Найруулгын санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “1 дүгээр зүйл” гэснийг “1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 6.2 дахь хэсгийн 4 дэх заалтын “Хот байгуулалт,” гэсний дараа “барилга,” гэж, 2 дугаар зүйлийн “1 дүгээр” гэсний өмнө, 3 дугаар зүйлийн “2 дугаар” гэсний өмнө болон 4 дүгээр зүйлийн “3 дугаар” гэсний өмнө “энэ хуулийн” гэж тус тус нэмэх. Санал



гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол санал гаргасан Аубакир. Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам төслийн ТЭЗҮ, зураг, төсөв Улаанбаатар гэснийг Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ төслийн ТЭЗҮ, зураг, төсөл Улаанбаатар гэж өөрчлөх. Энэ саналыг нь, найруулгын шахуу юм байна шүү дээ. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж уг санал дэмжигдсэн байна. Өөр ямар санал байна вэ? Өөр саналтай гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн алга байна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёрдугаар хэлэлцүүлгийг хийж дууслаа.

22.31 цаг

**Гурав. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Васгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

3 дахь асуудалдаа оръё. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад оролцож байгаа албан тушаалтнууд өмнө миний дурдсан албан тушаалтнууд хэвээрээ. Төсвийн байнгын хорооноос Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн

тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолуудын төслүүдэд дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргаж ирүүлсэн. Уг хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Дондогмаа танилцуулна. Дондогмаагийн микрофон 6 дугаар микрофоныг өгье. Энэ нөгөө дагаж өргөн мэдүүлсэн хуулиудтай холбоотой гарсан хууль зүйн дүгнэлтийг танилцуулна.

**Ч.Дондогмаа:** Төсвийн байнгын хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс хийсэн хууль зүйн дүгнэлтийг танилцуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 13 хууль, 2 тогтоолын төслүүд Үндсэн хууль бусад хуульд нийцэж байгаа талаар хууль зүйн дүгнэлт гаргалаа.

Нэгд.Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. 1 дүгээрт төсөлд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, инженерийн тооцоо, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах, тохируулах, уг барилга байгууламжийн ашиглалтад, барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбогдсон хоорондоо уялдаа бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг бүхэлд нь хамарсан, эсхүл зураг төсөл, барилгын угсралт тохируулгын ажил гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлтэй зохион байгуулж болно гэсэн зохицуулалтыг тусгажээ.

Гэвч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд түлхүүр гардуулах нөхцөлтэй зохион байгуулах тендер шалгаруулалтыг чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулж болохоос өөр тодорхой зохицуулалт тусгаагүй байна. 2015 оны 12 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан, батлагдан 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд түлхүүр гардуулах гэрээ гэж барилга байгууламжийн зураг, төсөл, инженерийн тооцоо, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбогдсон хоорондоо уялдаа бүхий хэд хэдэн ажил, бараа, үйлчилгээг бүхэлд нь хамарсан нэг гэрээг ойлгохоор тусгасан байсан.

Иймд тендер шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлөөр зохион байгуулж болохоор тусгаж байгаа бол өндөр үнийн дүнтэй бүтээн байгуулалтын төслүүдэд хэрэгжүүлэхдээ ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий гүйцэтгэгчтэй төслүүдийн хувьд Монгол Улсын эрх ашигт нийцсэн, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, ашигтай зохицуулалтуудыг буюу гэрээний үнийн үнийг хэрхэн тооцох, төлбөр төлөх аргуудыг хэрэглэх талаар хуульд тусгасан зүйтэй гэж үзэж байна.

2-т төслийн 2 дугаар зүйл буюу хуулийн 3.3.1, 3.3.7-д ЗГ-аас хөгжлийн бодлого, шинэтгэл, шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалт хамаарахгүй байхаар тусгасан байна. Хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий

тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хүн, хуулийн этгээдийг хэрхэн сонгох, ямар хэмжүүрээр үнэлэх, төсөвт өртөг нь ямар байх талаар зохицуулалт байхгүй, зохицуулалт байхгүй байна.

Мөн нэр томъёоны хувьд дээр дурдсан хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр гэдэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр гэсэн баримт бичигт хамаарах эсэх нь эргэлзээтэй, зохицуулалтын хувьд ойлгомжгүй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.8-д тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх гэсэн хуулийн эх бичвэрт тавигдах шаардлага, мөн хуулийн 30.1.1-д Монгол Улсын Үндсэн хууль бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх, 30.1.2-т нэг нэр томъёогоор өөр, өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх гэсэн шаардлагад нийцээгүй байна.

3 дугаарт. Төсөлд бараа, ажил, үйлчилгээний цар хүрээ, төсөвт өртөг өндөр, хоорондоо уялдаа бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг цогцоор нь гүйцэтгэх шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чадавх туршилагын өндөр чадамжтай, чадамж бүхий аж ахуй эрхлэгчдийг урьж, тендер шалгаруулалтад оролцуулан, хэлэлцээ хийх замаар гэрээ байгуулах зохицуулалт бүхий чадавхад суурилсан хэлэлцээний аргыг шинээр нэмсэн байна. Ингэхдээ төслийн 1 дүгээр зүйлийн 7-д буюу хуулийн 36<sup>1</sup>.9 дэх хэсэгт хуулийн 36<sup>1</sup>.1-д заасан жагсаалтыг тендер шалгаруулалтыг зохион байгуулах этгээдийн хамт ЗГ батлахаар тусгасан.

Гэтэл төсөлд тусгасан 36<sup>1</sup>.1 дэх хэсэгт ямар нэг жагсаалтын талаар дурдаагүй бөгөөд дээрх жагсаалт нь бараа, ажил, үйлчилгээний жагсаалт, эсхүл чадавх өндөр, чадавх туршилагын өндөр чадамж бүхий аж ахуй эрхлэгчдийн жагсаалт аль болохыг тодорхой тодорхойлоогүй, түүнчлэн зохион байгуулах этгээдийн хамт батлахаар тусгасан нь ойлгомжгүй. Тендер шалгаруулалтыг тухай бүр зохион байгуулан, тендер шалгаруулалтыг зохион байгуулан явуулах бүрд ЗГ жагсаалт батлахаар ойлгож байна. Иймд төслийн 36<sup>1</sup>.1-д ЗГ батлах жагсаалтын талаар тусгах нь зүйтэй байна.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 31.5-д тендер шалгаруулалтыг тухайн аргаар 2-оос доошгүй удаа зарлахад 1 ч тендер ирээгүй бол төрийн болон орон нутгийн өмчит эсхүл өмчийн оролцоотой хуулийн этгээдээр тухайн худалдан авах бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгүүлж бол гэж тусгасан байна. Ингэхдээ тухайн бараа, ажил, үйлчилгээ, үйлчилгээг гүйцэтгүүлэхдээ аль төрийн болон орон нутгийн өмчит эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, тэдгээрийг хэрхэн сонгон шалгаруулах, ингэхдээ хуульд заасан тендер шалгаруулалтын ямар нэг аргыг хэрэглэх эсэхийг тодорхойлоогүй байна. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1-д энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална гэж заасан юу зарчмыг, зарчмыг баримтална гэж заасныг баримтлахгүй байх нөхцөл үүсэх үндэслэлтэй байна.

5.Төслийн 1.1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу хуулийн 36<sup>1</sup>.9-д заасан жагсаалтад багтлагдсан төсөл, арга хэмжээний шалгаруулалтыг

санхүүжилтийн эх үүсвэр батлагдахаас өмнө эхлүүлж болно гэж зохицуулалтыг нэмжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7-д Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлаар асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд төрийн санхүү, зээл, татварын бодлого, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхээр заасан. Арай болоогүй. Улсын Их Хурлаар хэлэлцэн баталдаг холбогдох хууль тогтоомжоор боловсруулж тодорхой шаардлагыг ханган өргөн мэдүүлэх нарийн зохицуулсан процесстэй төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох худалдан авах ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй байхад жагсаалтад багтсан төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг эхлүүлэн явуулах нь хуулийн зөрчилтэй байна гэж үзэхээр байна.

2 дугаарт, 2.2 дугаарт Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Хуулийн төсөлд Цөмийн энергийн тухай хуулийн холбогдох зүйлүүдэд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэж заасны боловсролын гэснийг цөмийн энергийн гэж өөрчлөхөөр заажээ. Үүнтэй уялдуулан тус хуулийн 10.2-т цөмийн, комиссын дарга нь шинжлэх ухааны асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн байна гэж заасны шинжлэх ухааны гэснийг цөмийн энергийн гэж өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

2.3-д Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар. Улсын Их Хурлаас Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хууль, Төр, хувийн

хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Концессын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийг 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдөр тус тус баталж, эдгээр хуулиуд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхэлж дагаж мөрдөхөөр заасан. 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Концессын тухай хуулийн үйлчлэл тус хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснээр нэгэнт зогссон байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 26<sup>1</sup>.1-д хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хүчингүй болгосноор өмнө нь хүчингүй болсон хуулийн үйлчлэл сэргэхгүй гэж заасан зарчмын дагуу Концессын хуулийн үйлчлэл дахин сэргэх боломжгүй юм. Хууль тогтоомжийн хуулийн тухай, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27.1.3-д өмнө нь үйлчилж байсан хууль, эрх зүйн зохицуулалтын дагуу үүссэн харилцаа, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг шинэ хуулийн дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох болон сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл, арга зам, хариуцлагыг зохицуулах хэлбэр, мөн 27.1.5-д өмнөх хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн зарим хэсэг хүчин төгөлдөр үйлчлэх тодорхой нөхцөл тохиолдол зэрэг асуудлыг хуулийг дагаж мөрдөх журмаар зохицуулна гэж заасан.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд шинэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Концессын хуулийн дагуу байгуулагдсан концессын гэрээ болон бусад дагалдах гэрээний нөхцөл нь хүчин төгөлдөр хэвээр байхаар, өмнө нь байгуулагдсан концессын гэрээ нь шинэ хуультай зөрчилдвөл гэрээний нөхцөлийг баримтлахаар, шинэ хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө гарын үсэг зурагдсан концессын гэрээ, дагалдах

гэрээний нэмэлт, өөрчлөлт эсхүл сунгалт нь хүчин төгөлдөр байхаар тус тус заасан.

ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 3 дугаар бүлгийн 3.5-д хуучин байсан харилцаанд тулгуурлан шинээр эрх зүйн зохицуулалтыг хуульчлах тохиолдолд тухайн шинэ зохицуулалтыг баримтлах зарчим үйлчилнэ. Хэрэв тухайн харилцаанд хуучин зохицуулалтыг баримтлах бол энэ тухай хуулийн төсөлд тусгайлан заах шаардлагатай гэж заасны дагуу 2022 онд баталсан Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд түншлэлийн харилцаанд өмнөх хуулийн зохицуулалт буюу Концессын тухай хуулийг баримтлах гол зарчим зохицуулалтыг бүрэн тусгасан байна.

Тодруулбал хуульд шинээр үйлчлэх, хуульд шинэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх концессын гэрээ байгуулагдсан бол түүнийг цааш нь үргэлжлүүлэхээр зааж харин Концессын тухай хуулийн дагуу төсөл сонгон шалгаруулах уралдаан, сонгон шалгаруулах уралдаан, сонгон шалгаруулалт зарласан харилцаанд өмнөх хууль үйлчилнэ гэж тусгайлан аагаагүй байна. Эндээс үзвэл Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцсэн бөгөөд уг хуульд хуулиар зохицуулах ёстой агуулгыг хоёрдмол утгагүй бүрэн хуульчилсан байна.

Харин Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу Хуулийн 7-дүгээр зүйлээр энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт зарласан

тохиолдолд шалгарсан этгээдтэй Концессын тухай хуулийн дагуу концессын гэрээ, дагалдах гэрээг байгуулна гэсэн зохицуулалтыг нэмэлтээр оруулахаар заасан бөгөөд энэ уг хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийг буруу тайлбарлан хэрэглэж, улмаар хуулиар журамласан хэм хэмжээг зөрчсөн гэж үзэхээр байна.

3.Бусад хууль, Их Хурлын тогтоолын төслөөр төслийн талаар. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын ЗГ-ын хуульд, ЗГ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай, Төрийн захиргааны байгууллагын бүтэц, байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүд

Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжтой нийцэж байх бөгөөд төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо зөрчилгүй байна гэж үзлээ.

Хууль зүйн дүгнэлтийн дүгнэлт, санал хэсгийг уншиж танилцуулбал, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг буюу 10.14 дэх хэсгийн түлхүүр гардуулах нөхцөл гэсэн нэр томъёо, холбогдох зохицуулалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн бусад зүйл хэсэгт тусгагдаагүй байна. Иймд зохицуулалтыг тодорхой болгож тусгах эсхүл холбогдох хуулиас эшлэл хийх нь зүйтэй байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг буюу 48.9-д чадавхад суурилсан хэлэлцээний аргаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад баталсан төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг санхүүжилтийн эх үүсвэр батлагдахаас өмнө эхлүүлж болно гэж тусгасан нь Улсын Их Хурлын улсын төсвийг батлах онцгой бүрэн эрхэд халдсан гэж үзэхээр байх тул хасах саналтай байна. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас тухайн жилийн төсвийг батлаагүй байхад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг эхлүүлсэн байх нь Улсын Их Хурал уг төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг заавал батлах нөхцөл рүү оруулж байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл буюу 3.3.7-д ЗГ-аас хөгжлийн, Хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй байхаар заасныг тодруулах шаардлагатай байна. Тухайлбал хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр гэсэн ойлголт нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн, хуульд заасан хөгжлийн бодлогын баримт бичгүүд мөн эсэх, биш бол ямар бичиг баримт болохыг тодорхой тусгах.

Хэрвээ Хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлогын баримт бичигт хамаарах буй бол уг баримт бичгийг боловсруулах этгээд, байгууллагыг хуульд тодорхой тусгасан байгааг анхаарах нь зүйтэй байна. Төсөлд ЗГ-аас Хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол тендер сонгон шалгаруулалтад хамаарахгүй байхаар тусгасан нь хэт өргөн хүрээг хамарч, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан асуудлаар боловсруулж, хэрэгжүүлэхэд нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэсэн үндэслэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлахгүй байхаар хуулийн төслийг, төслийн заалтыг томъёолсон байна. Иймд төслийн 2 дугаар зүйл буюу 3.3.7-гийн Хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр гэснийг зөвхөн зөвлөх үйлчилгээгээр хязгаарлах эсэх асуудлыг оновчтой томъёолох шаардлагатай.

3.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хамруулбал зохих заалтыг орхигдуулсан нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэхээр байна.

4.Төр, хувийн хэвилийн түншилэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчингүй болсон Концессын тухай хуулийн дагуу төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт зарласан тохиолдолд шалгарсан этгээдтэй концессын гэрээ, дагалдах гэрээ байгуулахаар тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-д иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг шинэ хуулийн дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох болон сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл арга зам, хариуцлагыг зохицуулах хэлбэр, 27.1.5-д өмнөх хуулийн, хууль, эрх зүйн зохицуулалт нь тэдгээрийн зарим хэсгийг хүчин төгөлдөр үйлчлэх тодорхой нөхцөл тохиолдол гэдэг зэрэг асуудлыг хуулийг дагаж мөрдөх журмаар зохицуулахаар заасантай нийцээгүй байна. Танилцуулж дууслаа.

**Ц.Даваасүрэн:** Баярлалаа. Хэдүүлээ ингэх үү, одоо ингээд уг нь энэ дүгнэлттэй холбогдуулаад л асуулт асуух ёстой. Тэгэхдээ энэ нөгөө дагаж байгаа хуулиудыг бүүр хуулиас гадна бүүр зүйл нэг бүрээр нь хэлэлцдэг болчихсон юм байна лээ. Тийм учраас зүйл бүрээр нь хэлэлцэхдээ асуугаад явчихъя тэгэх үү? Зөрүүд гэж, асуу, асуу. Ингээд саяын гарсан хуулийн дүгнэлттэй холбогдоод асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн асууя.

**Б.Энхбаяр:** Баярлалаа. Тэгэхээр энэ төсөв дагуулж том хулгайг сүүлийн 4 жилд хийх гэсэн 4 дэх оролдлого үнэнд

гүйцэгдэж, мэргэжлийн Тамгын газрын дүгнэлтээр бол хуулийн хулгай хийх гэж байсан гэдэг нь нотлогдож байна. Тухайлбал хүчингүй болчихсон хуулийн Концессын хуулийг хэрэглэх гэж байсан асуудал хууль зөрчинө гэдгийг хэлж өгсөн байна. Тендерийн хуулийн 3.3.7 буюу ЗГ өөрөө Тендерийн хуулийг хэрэглэхгүй хэрэглэх үү, хэрэглэхгүй юу гэдгийг ЗГ өөрөө шийдэх ганцхан заалт байгаа байхгүй юу. Ерөөсөө ганцхан өгүүлбэр байгаа. Шаардлагатай гэж ЗГ үзвэл Тендерийн хуулийг хэрэглэхгүй байж болно гэж байгаа юм. Юу гэсэн үг вэ энэ? Ийм хуулийн техник байж болдог юм уу? Тэгвэл хууль тогтоох институт гэж байгаад яах юм, хууль гэж байгаад яах юм. Бид нар энд хэдэн жил хэлэлцэж, Тендерийн хууль гэж гаргаад яах юм.

ЗГ чинь гүйцэтгэх эрх мэдэл буюу хуулийг хэрэгжүүлэх үүргийг Улсын Их Хурлын өмнө хариуцдаг. Тэрнээс сонгож хэрэгжүүлдэг байгууллага биш байхгүй юу. Энийг нь би хэрэгжүүлбэ, энийг нь би хэрэгжүүлэхгүй гэж өөрөө шийддэг байгууллага биш. Сая бол Тамгын газар бол мэдээж төрийн жинхэнэ албан хаагчдаас бүрдсэн институт учраас зөөлөн хэлж байна. Зөөлөн, энийг анхаарах ёстой, нэг иймэрхүү хийдэл байна энэ тэр гэдэг байдлаар хэлж байгаа байхгүй юу. Тэрнээс биш саяын заалт бол шууд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдаж байгаа юм. Хууль тогтоох онцгой бүрэн эрхэд халдаж байгаа. Эрх мэдэл хуваарилах зарчимд нийцэхгүй асуудал байхгүй юу.

Тэгээд ер нь ингээд төсөв дагуулаад хугацаагаар шахаж байна л даа. 1 хоногийн зайтай өргөн бариад хэлэлцэх эсэхийг нь шийдсэн. Одоо хэлэлцэх эсэхийг нь шийдсэнээс 2 хоногийн дараа бид нар шууд саналын томьёолол руу орж байгаа. Харин Тамгын газар 2 хоногийн хугацаанд 9 хуудас болохгүй гэдэг дүгнэлт гаргаж амжсан байна харин. Тэгэхдээ сул хэлж байгаа юм.

Тэгэхээр би дүгнэлтээс асуух гэж байгаа нь тэгээд ийм их хийдэлтэй, ийм их зөрчилтэй хуулийн төслийг Улсын Их Хурал шөнийн 11 цагт сонсоод, тэгээд энийг хийдлийг нь арилгах, залруулах ажлыг шөнийн 12 цагт багтааж хийж амжих юм уу? Ямар томьёолол гарах юм бэ? Энэ бүр амин дээр тулчхаад байгаа юм уу? Төсөв дагуулж орж ирэх энэ 24 оны төсвийн тодотголтой яг нийцэх аминд тулчхаад байгаа юм уу? Асуултад.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** 1 минут өгчихье Энхбаяр гишүүнд.

**Б.Энхбаяр:** Тэргүүн шадар сайд Гантөмөр, Шадар сайд Доржханд нар бол энэ Тендерийн хуулийг бол ингээд нэг багцаар нь оруулж ирэх юм гэж яриад байгаа байхгүй юу. Өөрсдөө үзээ ч үгүй хууль. Тэгээд энэ төсөв дагуулж биш тусдаа тэр ЗГ энэ хуулиа өргөн бариад Их Хурал ийм нэг хоног, нэг цагийн хугацаа шахагдахгүйгээр хэлэлцэж, хэлэлцэх ёстой хууль байхгүй юу. Яагаад төсөв дагуулж байгаагийн утга бол ерөөсөө хууль тогтоогч, ард түмнийг мэдээллээр боомилж байгаад Төсвийн хуулийн хугацаанд баталдаг нөгөө хугацаагаар нь шахаж байгаад, танихгүй байх, мэдэхгүй байх, анзаарахгүй байх гэж хулгай хийх гэж байгаа ийм бодлоготой холбоотой.

Тийм учраас хамгийн ардчилсан олон хүнтэй парламент анхнаас нь ийм явдлыг өөгшүүлж таарахгүй. Тендерийн хуулийг тусад нь өргөн барь. Тусад нь ард түмэнд төслөө, үзэл баримтлалаа танилцуул. Тусдаа хэлэлцье. Тийм учраас энэ.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Хууль зүйн дүгнэлттэй холбогдуулаад тэгвэл манай дүгнэлт гаргасан Тамгын газрын холбогдох ажилтан хариулъя. Дондогмаа дарга хариулъя.

**Ч.Дондогмаа:** Байнгын хорооны, Дэгийн хуульд заасны дагуу Байнгын

хорооны, Байнгын хорооноос хууль зүйн дүгнэлт гаргах албан бичгийг ирүүлсэн. Энэний хүрээнд Тамгын газраас яаралтай горимоор өргөн мэдүүлж, ЗГ-аас энэ хуулийг 8 сарын 12-ны өдөр яаралтай горимоор өргөн мэдүүлсэн учраас хууль зүйн дүгнэлтийг бол шуурхай гаргаж өгсөн. Дэгийн хуулийн 34.2-т бол Тамгын газрын хууль асуудал, хуулийн асуудал хариуцсан нэгж хууль зүйн дүгнэлтийг ажлын 10-аас 15 өдрийн дотор гаргана гэж заасан. Тэгэхдээ нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн учраас ямар ч байсан дүгнэлтийг шуурхай гаргаж өгсөн.

Хууль зүйн дүгнэлттэй холбоотой асуудлаар бол Байнгын хороон дээр хэрвээ гишүүдийн санал гарвал санал саналын томъёоллоор хураагаад шийдвэрлэх боломжтой.

**Ц.Даваасүрэн:** Сая бид энэ төсвийн хүрээний мэдэгдэл дагаж өргөн мэдүүлсэн хуультай холбогдолтойгоор бас манай Их Хурлын гишүүд дийлэнх нь бас шинээр орж ирсэн гишүүд байгаа учраас бид нар Байнгын хорооноос болбол энэ дагаж өргөн мэдүүлсэн хуулиуд дээр бол хууль зүйн дүгнэлт гаргуулж байж шийдье гэсэн байгаа. Тэгээд хууль зүйн дүгнэлт гаргаж ирүүлсэн. Ирүүлсний дагуу болбол ажлын хэсэг дээр эдгээр хуулиудын хуулийн зөрчилтэй гэсэн энэ зүйл, заалтуудыг хасахыг нь хасаж, буцаахыг нь буцаах шийдвэр бол гаргасан байгаа.

Ингээд энэ нөгөө хууль, энэ дагаж өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороод бол дүгнэлтээ ирүүлсэн байгаа. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Уянга гишүүн танилцуулах ёстой, надыг танилцуулаач гэж хүсэлт гаргасан байна. Би танилцуулчихъя.

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн.

Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Аж үйлдвэржилтийн байнгын хорооны санал, дүгнэлтийг уншиж танилцууллаа. БОХХАА-н Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар танилцуулна. Ганбаатар гишүүний микрофоныг өгье. Энэ Баярбаатар гишүүнийг дуудах хэрэгтэй юм байна шүү.

**Г.Ганбаатар:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,



Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

БОХХАА-н байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх асуудал, дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс санал, асуулт гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүнд баярлалаа. ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна. Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье.

**Б.Мөнхсоёл:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын ЗГ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн.

ТББХ 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хурал хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй

хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын ЗГ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тухай, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна. Үгүй ээ харин сайн байна шүү дээ, идэвхтэй эхнээсээ.

**Б.Мөнхсоёл:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, шөнийн мэнд.

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16, 19-ний өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн Төр, хувийн хэвилийн түншилэлийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төр, хувийн хэвилийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвилийн түншилэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Төр, хувийн хэвилийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан аргаар төслийг зарлаж, сонгон шалгаруулах хугацааг мөрдөх боломжгүй гэж заасан нь шууд гэрээ байгуулах нөхцөл үүсэх эсэх, шууд гэрээ байгуулснаар өмнө нь гарсан хууль бус үйл ажиллагаа давтагдах эсэхийн талаар эрсдэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Г.Уянгахыг нар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан томоохон хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Гишүүн, энэ нэг жижигхэн үсгээр эхэлчихсэн байх юм. Гишүүн П.Сайнзориг Туул голын хурдны авто зам төсөл, Дархан хотоос Улаанбаатар хот руу чиглэсэн хатуу хучилттай авто замыг Хөшигийн хөндийн болон Дундговь аймгийн хатуу хучилттай авто замтай холбох, Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалт,

дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, бүсчилсэн Хөшигийн гээд биччихсэн байна Хөшигтийн, хөгжлийн хүрээнд томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд аймгууд хамтран ажиллах талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Байнгын хорооны хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаагүй бөгөөд хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье. Энэ их хэдүүлээ жоохон асуулт асуухгүй тэрэн дээрээ жоохон анхаарахгүй болбол 13 хууль, 2 тогтоолын төслийг зүйл бүрээр 47 зүйл хэлэлцэх юм байна шүү. Эхнийх эхний хэлэлцүүлгээ хийе.

Нэг.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан хэлэлцүүлэг хийе. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад л асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Саналтай гишүүн байна уу? 1 дүгээр зүйл дээр үү? Санал хэлье.

**Б.Энхбаяр:** Төслийн Худалдан авах ажиллагааны хуулийн 1 дүгээр зүйл бол гол нь чадавхад суурилсан.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Гишүүнээ энэ чинь өөр болчихсон юм байна лээ. Одоо нөгөө бөөнд нь биш болчихсон юм байна лээ. Энэ дээр зөвхөн миний ярьж байгаа энэ Төсвийн тухай хуулийн нөгөө 1 дүгээр зүйл дээр ярина та.

**Б.Энхбаяр:** Төсвийн тухай хуулиа?

**Ц.Даваасүрэн:** Тийм Төсвийн тухай хууль. Ингээд зүйл бүрээр нь.

**Б.Энхбаяр:** Төсвийг чинь хэлэлцчихсэн шүү дээ, одоо төсөв дагасан хуулиа хэлэлцэж байгаа биз дээ?

**Ц.Даваасүрэн:** Биш ээ биш энэ чинь ингэдэг юм. Тийм, Төсөв дагасан хуулиа. Одоо чинь ингэдэг болчихсон юм байна. Хуучин буюу бид нар бол ингээд нөгөө нэг хуулиудыг дагасан хууль нөгөө хуулийн төсөл дээр асуулт байна уу, үг байна уу гээд л явчхаад байдаг байснаа болиод харин тэгээд энэ чинь одоо байна шүү дээ ингэх юм байна. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зөвхөн 1 дүгээр зүйл дээр ирж байгаа байхгүй юу. Тийм. Алга байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуул, бас санал, энэ чинь нээрээ их төвөгтэй болчихсон юм байна. Энэ дээр чинь нээрээ бас санал хураалт явагдана. Энэ их тийм балай горим болсон юм байна даа, өөрчлөхгүй бол хэдүүлээ. Битгий зөрүүдлээд бай л даа чи. Төслийн 1 дүгээр зүйлийн, өөрийгөө юу гээд бодчихсон юм чи. Төслийн, тийм ээ тийм уг нь болбол яах вэ дагалдах хуулиудыг бөөндчихдөг байсныг бодоход бол энэ болбол бас дагалдах хууль бүрээр юу дүгнэлт гаргадаг болсон байна, дагалдах хууль бүрээр хэлэлцдэг болсон

байна сайн. Хуучин бол дагалдах хуулиудыг пад пад гээд л явчихдаг байсан юм. Тэр нь бол сайн болсон байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 28<sup>1</sup> дүгээр зүйлийн 28<sup>1.2</sup> дахь хэсгийн 08 дугаар сарын 15-ны гэснийг 8 дугаар сарын 10-ны гэж өөрчлөх. Санал гаргасан, 8 дугаар сарын 01-нийг гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн, Анар, Ариунзаяа, Батбаяр, Батболд, Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, Мөнхтулга, Пүрэвдаваа, Пунсалмаа, Түвшин, Уянга, Дав.Цогтбаатар, Чинбүрэн цаашид ажлын хэсэг гэнэ. Энэ саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Дэмжиж санал өгсөн уншигдсангүй. Тийм учраас дэмжсэнээр авна уу.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авахаар 17 гишүүн санал өгснөөс 9 гишүүн дэмжсэн тул уг санал дэмжигдсэн байна. 2 дугаар санал. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн, ахиад 2 дугаар зүйл рүү яах юм уу энэ нээрээ ёстой төвөгтэй болсон юм байна.

Тухайн төслийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүн байна уу, алга уу? 2 дугаар зүйл дээр байна уу? Тэмүүлэн гишүүн, нэрээ өгье, нэрээ өгнө шүү дээ. Одоо чинь яг нөгөө хууль шиг явдаг болчихсон юм байна лээ Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Би Төсвийн тухай хууль, зөвхөн төсвийн тодотгол дагаад Төсвийнхөө хууль дээр орж ирж байгаа энэ өөрчлөлтүүдийг дэмжихгүй байгаа. Хууль санаачлагчид нь буцаах саналыг болбол гаргах гэж байгаа юм. Энэ юу юм бэ гэхээр баахан цагт, он сар өдөртэй, сар өдөртэй, тэдний дотор, тэдний

гэсэн юм байгаад байгаа юм. Энэ аягүй амин чухал асуудлууд.

Энэ бол нэг талдаа бид нар дөнгөж жилийн өмнө зөв зүйлийг бий болгосон. 2 жил гаруй ажиллаж байж хийсэн төсвийн шинэчлэлийн бас нэг амин сүнс нь байгаад байгаа юм. Амин сүнс нь байгаад байгаа юм. Төсөв гэдэг бол өөрөө татвар төлөгчдийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгө. Бид бүхэн яагаад энэ ард түмний мэдэх эрхийг ингэж хаах гээд байгаа юм бэ? Өөрсдийнх нь төлсөн мөнгийг нь яагаад ил тод нээлттэй байлгахад ингээд татгалзаад байгаа юм бэ Сангийн яамныхан?

Яагаад бид нар энэ 10 сарын 1-нд өргөн баригддаг байсан төсвийг 9 сарын 1 болгоод нэг сар Улсын Их Хурал өөрөө ард түмний төлөөлөл болсон учраас бид нар энэ дээр чинь танилцъя гээд байна шүү дээ хангалттай мэдээлэл аваад. Энэ тодотгол орж ирж байгаа шиг ингээд нэг хоногийн дотор үзсэн болоод гурилдаад ингээд нэг батлаад байдаггүй байж болохгүй шүү дээ. 24 оны төсөв 30,4 их наяд төгрөг. Татвар төлөгчдийн төлсөн энэ их мөнгийг бид нар мэдээлчих эрх байх ёстой байхгүй юу. Ард түмэн өөрсдөө мэдмээр байна шүү дээ. Нэг сар энэ аудитынх нь байгууллага нь, ард түмний хяналтын байгууллага болсон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь ч гэсэн үзээд, мэргэжлийн талаасаа энэ санал, дүгнэлт, зөвлөмжөө гаргаг л даа.

Улсын Их Хурал 10 сарын 1-нд намрын чуулган эхлэхэд бид нар бүрэн мэдээлэлтэй болchoод, бөөс хуурсыг нь түүчээд, үнэн зөвөөр нь хариуцлагатай шийдвэрээ гаргадаг байя л даа. Яагаад Сангийн яам бид нар энэ шинэчлэлийн реформыг оруулж ирэхэд бүтэн нэг сараар ард түмэн мэдэх эрхийг, Улсын Их Хурал өөрсдөө онцгой энэ бүрэн эрх дээрээ зөв шийдвэр гаргах, нухацтай хандах нь шийдвэр бодлогыг гаргах гээд байхад яагаад хааж боогоод байгаа юм

бэ? Энэ мэдэх эрхийг нь хааж болохгүй шүү дээ.

Төсөв гэх энэ амин чухал асуудлыг хугацаагаар Сангийн яам шахаж хааж боогоод байж болохгүй шүү дээ. 10 сарын 1-нд төсөв өргөн барих ёстой, нэг ч удаа Сангийн яам 10 сарын 1-нээс өмнө өргөн барьж байгаагүй. Нэг ч удаа нэг ч мэдээллийг ил тод болгож байгаагүй. Нэг ч удаа Төсвийн байнгын хороо, Улсын Их Хуралд, ард түмэн тэр дундаа бүүр ил тод болгодоггүй та нар. Ийм хаалттай байдлаар хэр удаан явах гээд байгаа юм бэ? Төсвийнхөө сахилга бат харууцлагыг яаж бий болгоно гэж яриад байгаа юм. Ард түмний өөрсдийнх нь төлсөн мөнгийг бид бүхэн өөрсдөө танилцаач. Өөрсдөө юунд зарцуулах эрхийг нь нээж өгөөч гэдэг үзэх, харах, мэдэх эрхийг нь нээж өгөөч гэдэг асуудлыг л тавиад байгаа юм.

Олон улсын нийтлэг практик ийм байхад хаана ийм практик байгаа юм бэ манайхан шиг. Эргээд 10 сарын 1-нээс мэдээллээ өглөө гэдэг бүр үзүүлэхгүй байх, танилцахгүй байх эрхийг нь хаах үүднээс PDJ, JPJ болгоод ямар ч тэрэн дээр word дээр ажиллах эрхгүй болгож өгдөг байхгүй юу. Энэ болбол маш буруу зүйл. Энгийг хаах ёстой. Сангийн яам буцааж бид нарын шинэчлэлийг үгүйсгэж байгааг бол.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Тэмүүлэн гишүүний яриад байгаа асуудал бас үндэслэлтэй шүү. Энэ хуулийн өөрчлөлт болбол сая 6 сард гарсан, тэгээд хэдхэн сарын дараа дахиад өөрчилж байгаа юм. Тийм учраас ажлын хэсэг дээр энэ дээр нэлээн ЗГ-ын оруулж ирсэн саналыг бол хэлэлцээд хүлээж аваагүй. ЗГ-ын оруулж ирсэн саналыг яах вэ бид нар нэлээн нарийвчилж тооцож байгаад, тэгээд холбогдох өөрчлөлтийг оруулаад 9 сарын 15-наас өргөн мэдүүлэхээр өөрчлөлт оруулсан байгаа. Ингээд саналыг та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийн.

2 дугаар зүйл. 2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтын “7 дугаар сарын 8-ны” гэснийг “07 дугаар сарын 25-ны” гэж, 8.4.2 дахь заалтын “7 дугаар сарын 20” гэснийг “08 дугаар сарын 05-ны” гэж, 8.4.3 дахь заалтын “7 дугаар сарын 25-ны” гэснийг “08 дугаар сарын 10-ны” гэж, 8.4.4 дэх заалтын “8 дугаар сарын 15-ны” гэснийг “08 дугаар сарын 1-ний” гэж, “9 дүгээр сарын 1-ний” гэж, 8.4.5 дахь заалтын “9 дүгээр сарын 1-ний” гэснийг “09 дүгээр сарын 15-ны” гэж, 8.4.7 дахь заалтын “9 дүгээр сарын 25-нд” гэснийг “10 дугаар сарын 01-ний” дотор гэж, 8.4.8 дахь заалтын “9 дүгээр сарын 20-нд” гэснийг “09 дүгээр сарын 25-ны дотор” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулъя. Уг саналыг 17 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 64,7 хувийн саналаар дэмжигдсэн байна. Манайхан наашаа суугаарай.

3 дугаар. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Санал хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгөөрэй. Алга байна. Уг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Уг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух

асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал Төсвийн тухай хууль дээр гарсан байгаа. Тэмүүлэн гишүүний санал байгаа юм уу? Хураалгая.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулаад Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Энхбаяр нарын гаргасан санал байна. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн санал байна. Энэ саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжсэн байна. Энэ санал унасан байна.

7.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарим зүйл анги хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлье. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

8.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, анги хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүн байна уу? 1 дүгээр зүйл дээр, нэрээ өгье. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн асуултаа асууя.

**Б.Энхбаяр:** Сая бид энэ Тендерийн хуулийн өөрчлөлтийн талаар Улсын Их Хурлын Тамгын газрын дүн шинжилгээний дүгнэлттэй танилцсан. Энэ дүгнэлтээр бол нэлээн хийдэлтэй байна гэсэн. Энэ хийдлийг нь арилгаад санал хураах гэж байгаа юм байна. Ажлын хэсгээс оруулж ирсэн 6 санал байна, хураах гэж байгаа юм байна. Энэ 6 саналд саяын дүгнэлтэд дурдсан хийдлийг арилгасан санал нь алга байна, алга байна.

Өөрөөр хэлбэл баахан хийдэлтэй гээд Тамгын газар нь дүгнэлт гаргачаад байхад тэр хийдлийг нь арилгахаар оруулж байгаа санал хураалт дотор чинь тэр хийдлийг залруулсан юм алга байна. Жишээлбэл 36<sup>1</sup>.4 чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх мэдэгдэл, тендер ирүүлэх, хэлэлцээ ирүүлэх журмыг нь тендерийн баримт бичгээр заана гэж байгаа юм. Энэ журмыг чинь хуульд нь заадаг байхгүй юу даа. Хуульд нь өөрт нь бичдэг байхгүй юу. Ямар хугацаанд ирүүлэх юм, яаж хэлэлцээгээ хийх юм, яаж мэдэгдлээ явуулах юм гэдэг юмыг чинь хуульд өөрт нь бичдэг болохоос тендерийн бичиг баримт нь бичнэ гэж ийм хууль баталдаггүй юм. Тэгвэл энэ тендерийн бичиг баримтыг чинь хэн баталдаг вэ гэхээр захиалагч буюу тухайн сайд баталж байгаа юм. Сайд болгон өөр өөр мэдэгдэл, өөр өөр журам, тендерийн бичиг баримтаа шийдвэрлэх ийм эрх олгох гээд байгаа юм. Тэр хууль өөрөө хэрэглээ дээрээ өөр өөрөөр үйлчлэх байдлаар эрх олгосон журам процессыг бичдэггүй журамтай.

2-т энэ ээлжит бус чуулганы нээлт дээр Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайдын амнаас нэг, нэг үг нийтлэг гарсан. Журмуудыг цэгцэлнэ гэж. Энэ журмууд бизнесийн эрх чөлөөг хааж байна, хүний эрхэд халдаж байна, цаашид хуулиас гадна хуулиас 4, 5 дахин их болсон энэ журмуудыг цэгцэлнэ, журмуудаар ер нь аливаа харилцааг

зохицуулахаас түдгэлзэнэ гэсэн. Тэгсэн чинь нөгөө чадавхад суурилсан хэлэлцээрийнхээ гол юмнуудыг тендерийн бичиг баримт заана гэдэг ийм хуулийн төсөл оруулж ирж байгаа байхгүй юу? Хууль ойлгомжтой байх ёстой. Энэ.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Дэгээрэй харин энэ чинь яаж зохицуулсан билээ? 3 номерын микрофон, энэ яг л хууль шиг л болчихсон юм байна л даа. 3 номерын микрофон хариулъя.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль буюу олон улсын нийтлэг нэршилээр бол Тендерийн тухай хуульд дэлхийн улс орнууд 4 үндсэн ийм зарчмыг баримталж байгаа юм. 1 дүгээрт Юнистралын зарчим, 2 дугаарт FIDIC үлгэрчилсэн дүрэм, 4 дүгээрт Дэлхийн банк, IFC-н Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орсон улс орнуудын баримтлах журам, 4 дүгээрт OECD буюу ил тод нээлттэй байх ийм зарчмыг баримталж байгаа. Энэ хүрээнд энэ удаагийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд бид нар саяын дурдсан зарчмуудыг аль болох түсгахыг зорьж ажилласан гэдгийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм.

2 дугаарт саяын Энхбаяр гишүүний асууж байгаа асуулт болохоор нөгөө чадавхад суурилсан хэлэлцээний аргыг энэ удаагийн Тендерийн хуульд оруулж ирсэн нь хэт ийм явцуу, ЗГ хэт ийм субъектив байр суурь илэрхийлж байна гэдэг ийм зүйлийг ярьж байна л даа. Тэгэхээр яах вэ Юнистралын зарчим бол ерөөсөө л нөгөө хөгжиж байгаа орнуудад зориулсан хамгийн хямд үнэтэй тендерийг тухайн захиалагч сонгон шалгаруулах ийм зарчмыг баримталдаг зүйл байгаа. Бусад саяын тэр миний дурдсан нөгөө 3 тэр зарчим бол ил тод байх, инженерингийн зөвлөх инженерингийн байгууллагуудын

үлгэрчилсэн дүрэм журмыг шингээх энэ тэр аргуудыг хийгээд, тэгээд хэлэлцээний аргаар тендерт санал ирүүлсэн ААН байгууллагуудын саналуудаас магадгүй 2, 3, 4 ААН байгууллагуудын саналууд дээр хэлэлцээр хийж эхэлнэ. Тэгээд хэлэлцээрийн явцад санал өгсөн ААН байгууллагууд үнээ бууруулж болно. 2 дугаарт чанарын шаардлага дээр өөрчлөлтүүд гаргаж болно. Энэ болгон дотроос нөгөө захиалагч өөрөө аль нь хамгийн их давуу буулт хийж, захиалагчид хамгийн их чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлье гэсэн энэ ААН-ийг сонгон шалгаруулах ийм олон улсад тогтсон аргыг энэ чадавхад суурилсан хэлэлцээрийн арга гэж 1 дүгээрт үзэж байгаа юм.

2 дугаарт бараа, бүтээгдэхүүн худалдаж авах энэ үйл явцад тухайн салбар яам болон мэргэжлийн холбоодоос чадавхын тэр шалгуур үзүүлэлтүүдийг ингэж тусад нь жагсаалт гаргаад, үнэлгээний хороонд ороогүй тухайн салбарын яамнаас энэ чадавхын шалгуурын үнэлгээг авах ийм аргыг оруулж ирж байгаа юм. Тухайлбал дэлхий нийт жил болгон барилгын техник технологи, технологиуд дэвшил гарч байгаа юм. Тэр болгоныг жил болгон салбарын яам нь барилгын бүтээц хийц дээр ийм технологиуд шинээр орж ирсэн. Бетоныг орлохуйц ийм арга барилууд орж ирсэн гэдэг энэ шалгуур үзүүлэлтээр тухай бүрдээ ийм хувьсан өөрчлөгдөж, үнэлэлт дүгнэлтүүд өгөх илүү.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Тодруулъя, Энхбаяр гишүүний микрофон.

**Б.Энхбаяр:** Нямбаатар дарга бол энийг бол ингэж ойлгоно гэдгийг хэлж байна. Тэгэхдээ ингэж ойлгоно гээд сая хэлж байгаа юм нь энэ төсөл дээр байхгүй байгаад байгаа байхгүй юу. Унишхаар ийм ингэж хэлж байгаа юм нь байхгүй, ойлгогдохгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг чинь бол манай Гантөмөр сайд бол нэг өөрөөр ойлгоно, манай

Дээгий ах бол бүр өөрөөр ойлгоно шүү дээ. Тийм, бүр өөрөөр ойлгоно манай Дээгий ах бол. Тэрийг бол мэдэж байна. Яагаад гэхээр энэ төслийн 54.12-т ингэж байгаа байхгүй юу. Энэ чадавхын болон туршилагын оноо олгох журмыг нь салбарын сайд батална гэж байгаа байхгүй юу. Тухайн сайд ямар тархины хэмжээтэй, хэр зэрэг шуналтай, хэр зэрэг хууль мэддэг эсэхээс хамаарч энэ журам батлагдах гэж байгаа байхгүй юу өөр өөрөөр.

Тэгтэл хууль ингэж тэр хүн өөр өөр байхаас хамаарч үйлчлэх боломж олгосон хууль гэдэг бол өөрөө хуулийн нэгдмэл байдал, ойлгомжтой байдал, тодорхой байдал гэдэг энэ хэдэн зарчмуудыг чинь бүгдийг нь нулж байгаа байхгүй юу. Тэр тусмаа энэ Тендерийн хууль шүү. Тэр тусмаа энэ 40 тэрбум долларын төсөл шалгаруулах эрх олгох гэж байгаа хууль шүү. Тийм учраас би энийг төсөв дагуулж биш, шөнийн 12 цагт босон суун биш, одоо энд салбарын сайд нараас нэг ч хүн алга. Би жишээлбэл Дээгий ахыг яаж ойлгож байгааг асуумаар байна. Би Батсуурь сайдаас Барилгын сайд энийг яаж ойлгож байгааг би асуумаар байна жишээлбэл. Би Чойжилсүрэн сайдаас асуумаар байна. Чойжилсүрэн сайд бас их өөрөөр ойлгодог хүн шүү дээ, бас л их өөрөөр ойлгодог юмыг бол. Тийм учраас ийм эрх олгосон ийм хуулийн төсөл байж болохгүй л гэж үзэж байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Баярлалаа, оройн мэнд хүргэе бүгдэд нь. Мэдээж яах вэ асуудлууд дээр бас тал талын байр сууриудыг сонсож улам чамбайруулаад явах нь зөв байх. Ер нь бол яах вэ зүгээр Монгол Улс бас цаашидаа хөгжих ёстой. Өнөөдөр ерөөсөө Тендерийн хууль дээр чинь ерөнхийдөө харахаар open tenderийн, тэгээд single source буюу нэг эх сурвалжаас худалдан авах ажиллагаа л үндсэндээ хуульчлагдсан. Гэтэл энэ

томоохон төсөл хөтөлбөрүүдийг явуулах, ер нь зүгээр энэ хөгжиж байгаа орнуудын жишгийг харах юм бол Тендерийн хуулиуд дээр нь ерөөсөө нөгөө б арга бол түгээмэл нийтлэг байгаа байхгүй юу. Strict tender, request for proposal гэдгийг монголчилбол юу гэж хэлэх юм, ... stage 2 шатлалтай тендер ч гэдэг юм уу энэ бүх үйл явцууд чинь Монгол Улсын тендерийн хуульд байхгүй байгаа учраас том тендерүүд чинь явахгүй байна.

2 дугаарт яах вэ дэд бүтцийн төсөл болгон дээрээс энэ техникийн бичиг баримтууд өөр өөр, санал авах хугацаа өөр өөр тогтоогддог зүйлүүд байдаг. Энийгээ харин бид нар бас ил тод зүгээр л тэр процедурын дагуу олон нийтэд мэдэх тэр эрхийг нь хангаад явах талдаа л байна. Түүнээс биш бүх энэ дэд бүтцийн төслүүд болгон дээр нэг горимоор явна гэх юм бол Монгол Улс бас тодорхой хэмжээний бас, бас л юу гэдэг юм хөрөнгө оруулалт тэр төслийн онцлогоос шалтгаалаад асуудлууд бас өөрөөр эргэхийг бас үгүйсгэхгүй. Тэгэхээр бас тодорхой хэмжээний энэ уян хатан байдлууд бол байдаг. Энийг бол би зүгээр хэлмээр байгаа юм.

2 дугаарт яах вэ зүгээр одоогийн энэ тендерийн энэ асуудлаар бол томоохон төсөл хөтөлбөрүүд явахад бол цүнхний компаниуд орж ирдэг, тэр тендерээ аваад зардаг. Өнөөдөр бол яах вэ тендер Концессын хуулиар авсан лиценз сонгон шалгаруулалтаар гэх юм бол Монгол Улс жишээ нь эрчим хүчний чадлын дутагдлаас гарчихсан байх ёстой байхгүй юу. Аваад л явчихсан, хэн ч хэрэгжүүлдэггүй. Тийм учраас энэ дээр чаддагтай нь тэр know how мэдлэг туршилагатай тэр нөхдүүдийг бид нар олж авчирч бас Монгол Улсад мэдлэг, ажлын байр энэ залуучуудад нь ажлын байр, цаашидаа энэ туршилага нь, мэдлэг нь энэ know how нь Монгол Улсад үлдэх ёстой юм. Өнөөдөр яг томоохон замын, зам, эрчим хүч бүгдээрээ гэхэд манайх бол үндсэндээ ТЭЗҮ-ээ ч хийж чадахгүй



байгаа шүү дээ. Нийтлэг байдлаар. Ийм чадавхтай боловсон хүчин ч манай Монгол Улсад хомс байна.

Тэгэхээр би энэ юу гэдэг юм асуудлыг оруулж ирж бас энэ томоохон хөгжлийн төслүүдийн гацааг гаргах. Нэгэнт Монгол Улсын бас юу гэдэг юм байхгүй технологи мэдлэг орж ирэх учраас бас энэ аргыг хэрэглэж байж энэ томоохон яригдаж байгаа энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтууд чинь явах юм биш үү? Мэдээж яах вэ зүгээр энэ дээр болгоомжлох тэр асуудлуудаа Энхбаяр гишүүний хэлж байгаа, Лодойсамбуу гишүүний хэлж байгаа тэр зүйлүүдийг аль болохоор хяналттай, ил тод байлгах асуудал руу явах нь зөв. Энэ шууд гэрээ хийх гээд байгаа зүйл биш гэж бодож байна.

Тэгэхээр би ажлын хэсгээс энэ Энхбаяр гишүүний асуултад бас илүү тодорхой болгочихмоор байгаа юм. Үнэхээр 40 тэрбум долларын юмыг шууд хийх гээд байгаа юм уу? Энэ чинь бол шал өөр зүйлүүд байгаа гэж би зүгээр ойлгож байгаа шүү дээ. Энэ чинь тендер худалдан авалтын бас л нэг сонгон шалгаруулалтын арга. Энэ шууд 4, 5 компанитай уулзаад л шууд ингэчихдэг зүйл биш. Энэ чинь өөрөө оролцох хүсэлтүүд ирдэг. Эргээд чадавхтай хүмүүсийг бид олж судалдаг, эргээд энэ гадаад худалдааны бодлогоо ч бодох ёстой. Энэ юу гэдэг юм том төслүүдийн чинь ард гадаад худалдааны төлбөрийн.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Санал хураалгана гээгүй юм уу Энхбаяр? Үгүй ээ бүхэлд нь гэвэл яах вэ энийг хэлэлцэж дууссаны дараа саяын Тэмүүлэн гишүүн шиг бүхэлд нь хураалгах юм байна шүү дээ тийм ээ? Санал алга байна. Тийм. Тэгэхээр чи яг 1 дүгээр зүйл дээрээ санал

гаргах ёстой болбол 1 дүгээр зүйл дээрээ хураалгахгүй бол энэ чинь нөгөө зүйл зүйлээр нь хэлэлцэх юм байна. Одоо би бол байна шүү дээ 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад ажлын хэсгийн гаргасан саналыг хураалгана. АН-ын гаргасан саналыг хураалгана. Тэгэхээр чи 1 дүгээр зүйлтэй холбогдоод санал гаргах бол одоо гаргана. Тэгвэл тэрийгээ томъёолоод өгье. Микрофонд өгчих, тэрийгээ харин тэгээд хэлээд, тэгээд томъёолоод өгчих.

**Б.Энхбаяр:** 1 дүгээр зүйлийн төслийн 36<sup>1.4</sup> чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулах, тендер шалгаруулалт оролцох сонирхлоо илэрхийлэх мэдэгдэл, тендер ирүүлэх, хэлэлцээ ирүүлэх журмыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана гэснийг хасах саналтай байгаа. Энэ тендерийн бичиг баримтаар зохицуулдаг харилцаа биш байгаад байгаа байхгүй юу. Хуулиар зохицуулдаг харилцаа байгаад байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл зарчмын зөрүүтэй саналаа нааш нь ирүүлчих, хураалгана. Ингээд саналаа ирүүлчих. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд ажлын хэсгийн нэмэлт оруулах хуульд гаргасан ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. 1 хүн дутуу байна уу? Дуудчихъя. Ажлын хэсгийн саналын томъёолол. 1-гээр хураагаад, дараа нь ахиад 2-оор хураах юм байна шүү. Заяабал гишүүнийг орж ирэхээр хураах уу? Би уншиж л байя.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “Барилгын” гэснийг “Барилга, байгууламжийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналыг одоо хураалгана. Хэн, Заяабал гишүүнийг

ороод ирэнгүүт хэдүүлээ хураая. Саяын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар дэмжигдсэн байна.

2 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 35<sup>1.1</sup> дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: 36<sup>1.1</sup> шүү.

1.Улсын Их Хурлаас баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай аж ахуй эрхлэгчдийн тоо хязгаарлагдмал тохиолдолд гүйцэтгэгчийг энэ зүйлд заасан аргаар сонгож болно.” гэж өөрчлөх нь. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар дэмжигдсэн байна уг санал.

3 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 36<sup>1.1.9</sup> дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах: 36<sup>1.1.1.9</sup> биз дээ.

“36<sup>1.9</sup>.Энэ зүйлийн 36<sup>1.1</sup>-д заасан төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газар өргөн мэдүүлж, Улсын Их Хурал батална.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар уг санал дэмжигдсэн байна.

4 дэх санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 64,7 хувийн саналаар уг санал дэмжигдсэн байна.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар дэмжигдсэн байна.

2 дугаар, АН-ын санал, энэ чинь ер нь. Сая энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн энэ төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад АН-аас ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. АН-ын санал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 36 дахь зүйлийг иттрих нэг гэдгийг нь бичээгүй юм байна тийм ээ? Штрих 1 дэх юм шиг байна. 36<sup>1</sup> дэх зүйлийг бүхэлд нь хасах гэсэн санал гаргаж байгаа юм байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, уг санал унасан байна, дэмжигдсэнгүй.

2 дахь санал. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 54.11, 54.12, 15.7 дахь заалтуудыг хасах гэсэн санал гаргасан байна. Уг саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн орсноос 4 гишүүн дэмжиж, уг санал унасан байна.

Өөр 1 дүгээр зүйлтэй холбогдолтой юм байгаа юу? Энхбаяр гишүүний санал. Уг зүйлтэй холбогдуулаад Энхбаяр гишүүнээс гаргасан санал байна. Төслийн 36<sup>1.4</sup>-ийг хасах гэдэг санал гаргасан. Тайлбар хэлж болно. Энхбаяр гишүүн. Энхбаяр гишүүн санал хэлье.

**Б.Энхбаяр:** Энэ нөгөө тендер шалгаруулалтад оролцох, илэрхийлэх мэдэгдэл, тендер ирүүлэх, хэлэлцээ

ирүүлэх журмыг тендерийн бичиг баримт заана гэдэг заалт юм. Үгүй журамлана гээгүй. Энийг нь тендерийн бичиг баримтаар заана л гээд байгаа байхгүй юу. Тендерийн бичиг баримтад юу заахыг Тендерийн хуульд бичдэг байхгүй юу. Энэ тендер зарлаж байсан, шалгарч байсан. Тэгэхээр тендерийн бичиг баримтад заана гэдэг ийм Тендерийн хууль байдаг юм уу? Журмыг шүү дээ. Би энэ журам яриад байна шүү дээ. Яаж хэлэлцээ хийх журмыг тендерийн бичиг баримтад заадаг юм уу. Энэ чинь хуулиар зохицуулдаг эд байхгүй юу. Тэгээд энийг нь хасъя гэсэн саналтай байгаа байхгүй юу.

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, уг санал унасан байна. Тэгэхдээ энэ заалт дээр ер нь чуулганаар хэлэлцэхэд хэдүүлээ Их Хурлын даргаас чиглэл авч байгаад, энийг нэг эргээж харахгүй болбол тендерийн баримт бичигт журам оруулж гаргана гэж юм. Тэгэхээр бүх тендер дээр журам гарах болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол арай бас зохисгүй байгаа учраас энийг хэдүүлээ найруулах нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна. Уг саналыг түрүүн АН-ын бүлгийн гарсан санал гараад дэмжигдээгүй учраас энэ саналыг хураах боломжгүй байна. Тийм болно шүү дээ цөөнх болж болно шүү дээ. Тэг, тэг. Энхбаяр гишүүн цөөнх боллоо.

Ингээд 2 дахь руу нь орно тийм ээ. 2 дугаар зүйл рүү, яая зүйл нэг бүрээр ингэж явбал дуусахгүй дээ хэдүүлээ жоохон анхааръя. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй хэлэлцэж эхэлб. Асуулт асуух гишүүн байна уу? Алга. Энхбаяр гишүүн байгаа юм байна. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн асуулт асууя.

**Б.Энхбаяр:** Яах вэ энэ 2 дугаар зүйл дээр тэр гол зарчмын миний хэлээд байгаа заалт байгаа юм. Оруулах гээд байгаа юм. Тэр зөвлөх гэдгээ та ингээд өгүүлбэрийг хууль бол нөхцөл заасан хэсэг, тэгээд гол хэсэг, төгсгөл хэсэг гэсэн 2 шинжтэй. Энэ ингэж уншигдаад байгаа байхгүй юу оруулах гэж байгаа өөрчлөлт нь. ЗГ шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол Тендерийн хуулийг үйлчлэхгүй гэж уншигдаад байгаа юм. Та энэ хууль, үгүй ээ үгүй. Зүгээр өгүүлбэр нь нөхцөл нь ингэж уншигдаад байгаа байхгүй юу. ЗГ шаардлагатай гэж үзвэл Тендерийн хуулийг үйлчлэхгүй гэж байгаа юм. Тэгэхээр хууль үйлчлэх үү, үйлчлэхгүй юү гэдгийг ЗГ сонгож хэрэглэдэг, шийдвэрлэдэг Үндсэн хуулийн субъект биш. Хуулийг үйлчлүүлэхгүй гэвэл Улсын Их Хурал хуулиа хүчингүй болгох ёстой, хүчингүй болгох ёстой, үйлчлэлийг нь зогсоох ёстой.

Тийм учраас би энэ Үндсэн хуулийн техник ярьсан. Түрүүний Улсын Их Хурлын Тамгын газрын дүгнэлтэд энэ заалт бас орчихсон байна лээ. Энэ болохгүй байна гээд. Тэгэхдээ сул илэрхийлсэн байна лээ. Над шиг би бол Үндсэн хууль яриад байна шүү дээ. Эрх мэдэл хуваарилах зарчимд нийцэхгүй байгаа байхгүй юу. Хэзээ ЗГ хуулийг үйлчлүүлэх вэ, үйлчлүүлэхгүй юү, хэрэглэх үү, хэрэглэхгүй юү гэдгийг сонгож хэрэглэдэг байсан юм бэ. Ийм зарчим байдаг юм уу, ийм хууль зүйн техник байдаг юм уу. Энэ хуулийн төслийг энэ заалтыг ер нь хэн бичсэн юм бэ? Би Хууль зүйн яам бичээгүй гэж бодож байгаа. Энэ ямар ч хуульч хүний толгойноос ийм заалт биччихье гэж ухаанд нь гарахгүй. Энэ хуульч хүн бичээгүй энийг би баталгаатай мэдэж байна. Үүнийг харин хулгайч хүн бичсэн байгаа. Яг хулгай хийчихье гэж санаж сэдсэн хүн бол харин ийм, ийм санал сэдэж бичиж чадна. Энийг нь өөрчилбэ гээд ажлын хэсгээс оруулж ирсэн одоо санал хураах гэж байгаа зургаа дахь хувилбар дээр яг энэ

агуулга нь засагдаагүй байгаад байгаа байхгүй юу.

Өөрөөр хэлбэл ингэж өөрчилж гэж байгаа боловч ЗГ шийдвэрлэсэн бол Тендерийн хууль үйлчлэхгүй гэдэг тэр гол агуулга нь хэвээрээ байгаад байгаа байхгүй юу. Би энэ агуулгыг нь яриад байгаа байхгүй юу. Энэ зарчмыг нь. Төслийнх нь заалт юу гэж уншигдаад байна вэ гэхээр ЗГ шийдвэрлэсэн бол Тендерийн хууль үйлчлэхгүй гэж уншигдаж байгаа юм. Одоо манай ажлын хэсгийн оруулж ирж байгаа санал юу гэж өөрчлөддөд найруулчихсан байна вэ гэхээр байрыг нь солиод, урьд нь ингэсэн бол шаардлагатай гэж ЗГ-аас шийдвэрлэсэн бол Тендерийн хууль үйлчлэхгүй гээд дахиад биччихсэн байгаа. Тэгээд би энийг нь өөрчлөх ёстой гээд байгаа байхгүй юу. ЗГ-т хэзээ ч хуулийг сонгож хэрэглэх, үйлчлэх үү, үйлчлэхгүй юү гэдгийг шийдвэрлэдэг эрх ЗГ-т олгодоггүй л байхгүй юу даа.

**Ц.Даваасүрэн:** Тендерийн хуулийн 3.3 дахь заалт бол нөгөө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль хамаарахгүй байх 7 заалтын нэгэнд энэ орчхоод байгаа байхгүй юу. Тэгээд бид болбол бас энийг нэлээн яриад, энэ нэлээн өргөн цар хүрээтэй байна, тодорхойгүй байна гэдэг агуулгаар өөрчлөлтүүдийг бол оруулсан байгаа. Ингээд санал хураалт явуулах уу? Асуулт асууж дууссан. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Энхбаяр гишүүн саналтай гэсэн үү үгүй юу, санал хураалгах юм уу? Энхбаяр гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан юм байна.

Санал хураалт явуулъя. Үгүй ээ үгүй ажлын хэсгийн саналыг би хураалгана. Чи энэ дээр санал гаргаж байгаа бол бас хураалгаж болно шүү дээ. Үгүй ээ яах вэ тэгээд нэгэнт ажлын хэсэг гаргасан юм чинь би тэр олон хүнийхийг дураараа өөрчилж болохгүй байгаа байхгүй юу. Бид нэлээн ярилцаад л энийг, энэ чинь 15 хүн байгаа байхгүй юу ажлын

хэсэг нь. Ажлын хэсгийн саналыг хураая. Энэ заалтыг бол нэлээн ажлын хэсэг дээр ярьсан байгаа, нэлээн маргалдсан байгаа.

Ингээд төслийн 2 дугаар зүйлийн “Засгийн газраас хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хувь, хүн хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн болон” гэснийг “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаас нэр хүндийг нь тодорхойлсон, тусгай мэдлэг, ур чадвартай хувь хүн, хуулийн этгээдээс зөвлөх үйлчилгээ авах шаардлагатай гэж Засгийн газраас шийдвэрлэсэн болон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёолоор санал хураалт явуулъя. Энэ 17 гишүүн санал хураалтад оролцож, 6 гишүүн дэмжиж, энэ санал унасан байна. Тэгэхээр хуулийн төсөл хэвээрээ үлдэж байна гэсэн үг.

Энхбаяр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал байгаа юм уу? Бичээд өгчих. 3.3-ыг харах юм бол бас зүгээр аудитын газар хүртэл шинжээч томилохдоо энэ хууль хамаарахгүй гээд л орчихсон байгаа байхгүй юу. ЗГ жишээлбэл бас ингээд нөгөө нэг соёлын үнэт бүтээл юм авбал энэ хууль хамаарахгүй гээд л бас орчихсон л байгаа байхгүй юу. Соёлын энэ бүтээлийг авъя гэж ЗГ шийдвэр гаргана шүү дээ. Биш ээ биш, ЗГ-аас соёлын өв авна гэсэн бол гэж байгаа байхгүй юу. Ялгаа байхгүй л байхгүй юу наадахтай чинь ижилхэн. Жишээлбэл нэг гадаадаас ингээд нэг соёлын өвийн юм авъя гэж байна тийм үү. Тэгээд ЗГ тэгээд шийдвэрлэчихсэн болбол энэ хууль хамаарахгүй гээд заалт байж л байгаа байхгүй юу. Бас юмыг хэтэрхий тэгж гуйвуулаад байж болохгүй л дээ, адилхан юм байж л байгаа байхгүй юу.

Энэ нь нөгөө зөвлөх 7 зүйлд, 7 зүйлээр худалдан авах үйлчилгээний хууль хамаарахгүй гэдэг заалт байгаа дотор энийг нэмчхээд байгаа байхгүй юу. Тэр нь бол нөгөө зөвлөх үйлчилгээ л юм байна лээ. Энхбаяр гишүүний гаргасан горимын санал. Энэ хуулийн төслийн 2 дугаар зүйлийн, энэ чинь 3.3.7 дахь хэсгийг хасах гэдэг санал гаргаж байна. Тайлбар хэлэх чинь зөвхөн санал гаргасан гишүүн хэлнэ шүү дээ. Зөвхөн санал гаргасан гишүүн хэлнэ шүү дээ. Асууж болохгүй. Энэ саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж, уг санал унасан байна.

Нөгөө ЗГ-ынхаар орж ирсэн нэр хүндтэй этгээд гээд байгаа байхгүй юу. Тэрийг чинь яаж тогтоох юм бэ? Цөөнх болж болно. Тэгэхдээ энэ бол ингээд их муу хувилбараараа л үлдчихлээ дээ. Боловсруулна гэхээр нөгөө нэг, биш ээ биш нөгөө юуны нөгөө ЗГ-ын оруулсан санал дээр л болчихоод байгаа байхгүй юу. Бид нарын санал уначихсан байхгүй юу.

Ингээд дараагийн асуудалдаа оръё. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. 3 дугаар зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна гэвэл нэрээ өгье. 3 дугаар зүйл нь шүү. Алга байна. 3 дугаар зүйл дээр үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцье. 4 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцье. 5 дугаар зүйлээс асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Болохгүй болчихно шүү, болохгүй болчихно. Санал хураалт явбал хэцүү шүү. Ерөөсөө нэгхэн саналаар яваад байгаа байхгүй юу. Нэгхэн саналаар яваад байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Бүхэлд нь буцаая гээд байгаа тийм ээ. Бас бүхэлд нь буцаая гээд байгаа юм уу? Тус тусад нь хураалгах юм уу? Хамтдаа. Ингэх юм байна. Энхбаяр гишүүн, Лодойсамбуу гишүүн, Тэмүүлэн гишүүн, Цогтбаатар гишүүн нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ 24 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулж өргөн барьсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд энэ чинь нэмэлт, өөрчлөлт байгаа шүү дээ тийм ээ? Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь буцаая гэдэг санал гаргасан байна. Жаргалан гишүүн бас нэмэгдэж байгаа юм байна. Зураагүй л юм байна л даа уг нь тийм ээ. Тайлбар хэлж болно. Тайлбар, үг хэлж болно.

Ингээд энэ буцаая гэдэг саналыг дэмжье гэсэн саналын томъёолол санал хураалт явуулъя. 17 гишүүн санал хураалтад оролцож, 6 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараа нь, Энхбаяр гишүүн цөөнх болсон. Бүхэл, бүх зүйл дээр нь юм уу, аль нэг зүйл дээр нь юм уу? Тэгвэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор Энхбаяр гишүүн цөөнх болсон байна.

Хэлэлцэж эхэлье. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг хэлэлцье. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг хэлэлцье. 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Санал гаргаж, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2 дугаар хэлэлцүүлэг үү, энэ чинь эхний хэлэлцүүлэг нь үү? Эхний хэлэлцүүлэг тийм ээ. Анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрийг авъя. Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийг хийлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгье. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Саналтай юм уу энэ дээр. Харин тийм хураах юм байна шүү дээ. Түрүүний энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө дээр ямар нэг саналууд байхгүй байсан байгаа биз дээ. Саналыг нь, 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хараарай, уначхаад байна уу? Энэ ч жоохон найруулгын чанартай.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 22.9 дэх хэсгийн “тухайн татварын жилийн

татвар ногдох орлогын 1 хүртэл, 1 хувь хүртэлх хэмжээгээр хасаж хөнгөлнө” гэснийг “хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэлх хэмжээнээс хэтрэхгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар дэмжигдлээ. Бас нэг 2, 3 байгаа юм байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.2 дахь заалтын “тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан барьж байгуулах, ашиглах” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Сая дэмжиж санал өгсөн чинь аппарат ажилласангүй. Дахиж санал хураалгаж өгөхгүй юу.

**Ц.Даваасүрэн:** Хүчингүй болгох? Аубакир гишүүний гаргасан, тэгээд явчих уу? Тэгье. Тэгвэл тэгээд ахиад хэлчих. Горимын санал.

**Т.Аубакир:** Протоколд намайг дэмжсэнээр санал өгсөнд тооцохгүй юу. Дэмжсэн.

**Ц.Даваасүрэн:** Аубакир гишүүн дэмжсэн байна. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэн байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.3 дахь заалтын “дуу, дүрс, дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг,” гэснийг хасах. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9.6.спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын Үндэсний олимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжсэн үү? Микрофонд хэлчих, протоколд аваад нэмээд явчихъя.

**Ж.Батжаргал:** Дэмжиж санал өгсөн уншигдсангүй. Тийм учраас протоколд аваад, дэмжсэнээр тооцоодхооч.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүн дэмжиж санал өгсөн байна. 17 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэн байна.

5 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9.7.Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургуульд, дотоодын магадлан итгэмжилсэн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэг;” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6, 6 чинь 4 дүгээр зүйл юм байна. Энэ чинь ёстой төвөгтэй юм байна. АН

энэ хууль дээр 3 санал гаргасан байна. АН-ын саналыг хураалгая. Хуулийн төслийн 22.9.10 төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа гэсэн нь энэ салбарт үйл ажиллагаа явуул явуулдаг ААН байгууллагуудыг өмчийн хэлбэрээр ялгаварлан гадуурхаж байх тул 22.9.10-ыг боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа гэж өөрчлөн найруулах. Хувийн хэвшлийг оруулъя гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ боломжгүй гэж үзсэн ажлын хэсэг дээр. Ажлын хэсэг дээр ингээд хураачихсан юмыг болох юм уу. Энэ саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Алдаа гарсан учраас, гацсан учраас техник маань энэ саналыг хүчингүйд тооцоод, дахин санал хураалт явуулахад бэлтгэе. Техникийн ажлын хэсэг. Бэлтгэе. Бэлэн үү, ахиад үзэх үү? Болчихсон. Саяын АН-ын гаргасан саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гацчихсан байгаа учраас энэ саналыг хүчингүйд тооцъё. Дахиад техникийн бэлэн байдлыг хангая.

Гишүүдээ зүгээр нэг туршилтын санал хураалт явуулаад үзье. Туршилтын санал хураалт. Тэгвэл ингэх үү? Гишүүдээ байж бай, яришиг би горимын санал гаргачихъя. Техникийн бэлэн байдал хангагдах хүртэл гараар санал хураалт явуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Гар өргөөд, энийг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Хэдээс хэд вэ? 17-гоос 9 дэмжигдсэн байна.

АН-ын гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаад шууд гараа өргөнө үү. Дэмжихгүй шүү дээ нээрээ балрах гэж байна. 17-гоос 3, уг санал дэмжигдсэнгүй.

АН-ын гаргасан 2 дахь санал. Мөн энэ төслийн 22.9.11 Засгийн газрын

тусгай сангийн үйл ажиллагаа гэсэн нь төр өөрийн санд өгсөн хандивыг татвараас чөлөөлөх ач холбогдолтой тул хасах. Энэ чинь нөгөө Биеийн тамир спортын санд гэж байгаа юм байна лээ. Энэ болохгүй юм байна лээ. Энэ саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 17-гоос 1. Уг санал дэмжигдсэнгүй.

3 дахь санал. Төслийн 22.11-д хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг салбарын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн баталж хяналт тавина гэсэн нь уг зохицуулалтын анхны зорилго агуулгатай зөрчилдөж, төрийн албан тушаалтны оролцоо, хувийн ашиг сонирхлыг бий болгож байгаа тул хасах. Энэ саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү? Батжаргал гишүүнээ та дэмжиж байгаа юм уу? АН-ын гаргасан саналыг дэмжсэн 2 гишүүн, уг санал дэмжигдсэнгүй.

Дараагийнх нь юу билээ. Аль юм бэ тэр нь. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлъе. 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Нэрээ өгье. Алга байна. Санал хэлж, санал гаргаж, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлъе. Асуулт асуух гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

ААНОАТ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлъе. Асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Алин дээр байгаа



юм, 3 дээр үү? Сая би 3-ыг хэлсэн шүү дээ тийм ээ. 4-ийг уншсан, 4 нь аль нь юм.

Ажлын хэсгийн гаргасан санал байна зарчмын зөрүүтэй. Төслийн 4 дүгээр зүйл дээр. Төслийн 4 дүгээр зүйлийн “2031 он” гэснийг “2035 он” гэж өөрчлөх санал гаргасан байна. Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 17-гоос 9 дэмжигдлээ. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, эхний хэлэлцүүлгийг хийлээ.

Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцье. 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцье. Асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Аль дээр нь юм бэ, Байгаль орчин дээр үү? Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсон

тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байвал нэрээ өгье. Алга байна.

Монгол Улсын ЗГ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Санал гаргаж, үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ өгье. Алга байна. Монгол Улсын ЗГ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан хэлэлцүүлэг хийж эхэлье. Хэлэлцүүлэгтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрийг авъя. Алга байна. Үг хэлэх гишүүдийн нэрийг авъя. Алга байна. 1 дээр үү? Энэ үү? Төрийн болон, Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хууль, санал хураалт.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 37.1.3 дахь заалтын “хугацааг мөрдөх боломжгүй” гэсний дараа “тохиолдолд энэ хуулийн 37.1-д заасны дагуу хэлэлцээ хийж, гэрээ байгуулж болох бөгөөд төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэж, 37.1.3 дахь заалтын дугаарыг 37.7 дахь хэсэг болгон өөрчлөх. Санал

гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын санал хураалт. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 17-гоос 9 дэмжигдлээ.

2 дахь санал тийм ээ, мөн биз дээ? Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 37.7 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн болон 2-оос дээш аймгийн нутаг дэвсгэрийг дамжин хэрэгжих гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү? Болохгүй шүү. 17-гоос 9 дэмжигдлээ. Одоо аль нь билээ? 2 дахь нь.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Алга байна, үг хэлж санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Бас байгаа юм уу?

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал. Энэ нь үү тийм ээ? Санал. Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, мөн юм уу? Буцаах, энэ яг мөн юм уу? Чи будилаагүй биз. 2 дахь зүйл дээр шүү дээ. Зүйлээрээ явна шүү дээ. Үгүй ээ, энэ чинь чи сүүлд нь хэлэх ёстой байсан байхгүй юу. Үгүй ээ энэ чинь нөгөө зүйл бүрээр хэлэлцэнэ гээд 2 дугаар зүйлийг хэлэлцээд байна шүү дээ. 2 дугаар зүйлийг хэлэлцлээ.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцье. Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Төр, хувийн хэвилийн түншлэлийн, 3-ыг нь би асуучихсан уу?

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлье. Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан хэлэлцүүлэг хийе. Асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Энэ дээр 1 санал байгаа юм байна. Мөн биз дээ, биш юм уу? 6 байхгүй шүү дээ. Энэ дээр чинь 5 л юм байна шүү дээ. 6 байгаа юм байна.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцье. Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Болчихсон уу? Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье. 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал байгаа юм уу, аль нь юм бэ? Биш ээ энэ чинь 2-ыг нь хэлэлцсэний дараа болно шүү дээ, 2 гээд бичсэн байна шүү дээ. 2 дугаар зүйл гээд бас байна шүү дээ. 2-ыг хэлэлцэхгүй юм уу тэгээд? Зүйл бүрээр нь хэлэлц гэсэн юм байна шүү дээ. Болох юм уу? Ингээ нөгөө шинэ юун дээр бас жоохон будилаан гараад байгаа юм байна.

Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн санал гаргасан байна. Саналыг дэмжье гэдэг

саналын томъёоллын санал хураалтыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 17-гоос 9, дэмжигдлээ. Буцаая гэсэн учраас энэ чинь хураагдсан гэсэн үг байхгүй юу.

Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр, Лодойсамбуу, Тэмүүлэн, Жаргалан нар бас уг хуулийн төслийг буцаая гэж санал гаргасан юм байна. Энэ буцаах санал дэмжигдсэн учраас уг саналыг хураах шаардлагагүй.

Засгийн газрын хяналт шалгалтын тухай хууль уу? Та нар будилуузай. Засгийн газрын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу, санал гаргах? Алга байна. Ажлын хэсгийн 1 санал байгаа юм байна. Энэ ёстой ч хэцүү болчихсон юм байна даа.

Ажлын хэсгийн саналыг хураалгая зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Төслийн 1 дүгээр зүйлийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “хамаарна” гэснийг “адилтгана” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хэдээс хэд вэ? 17-гоос 9 дэмжигдсэн байна. 1 дээр өөр санал байхгүй тийм биз? Байхгүй.

Засгийн газар дахь хяналт шалгалтын тухай, Засгийн газар дахь хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцье. Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. ЗГ дахь хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийг хэлэлцье. Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлэх гишүүдийн, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна.

Засгийн газар дахь хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцье. Асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Засгийн газар дахь хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Энэ дээр өөр юм байхгүй байгаа биз дээ?

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал бий юу? Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцье. 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байна уу? Алга байна. Төрийн болон хяналт, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Төрийн өмчийг Нийслэлийн өмчид ишлэжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байгаа юу, дараа нь байгаа юм уу? 1 дээр алга байна.

Төрийн өмчийг Нийслэлийн өмчид ишлэжүүлэх тухай Засгийн газрын, Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дугаар заалттай холбогдуулан хэлэлцүүлэг хийе. Асуух асуулттай гишүүдийн нэрсийг

авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Ажлын хэсгийн гаргасан саналыг хураалгая. Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2. “Тавантолгой түли” ХХК-ийг нийслэлийн өмчид шилжүүлэхдээ хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, сайжруулсан төсвийн үнийг тогтвортой байлгахад шаардагдах нэмэлт санхүүжилтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. Санал гаргасан ажлын хэсэгт. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү? Хэд вэ? Гараа өргө, дэмжиж байгаа нь гараа өргөөрэй. Тэгэхгүй бол энэ баларна шүү, дэмжихгүй бол болохгүй шүү. Энэ чинь тэгвэл, энэ чинь тэгвэл алдагдалтай өндөр үнээр хэн ч авахгүй шүү дээ ард түмэн. Татаас өгье гээд байгаа байхгүй юу. Үгүй ээ ард түмэнд л тэр чинь хямд үнээр өгөөд байгаа шүү дээ.

Ингээ ямар ч гэсэн би тэгээд санал хураалт явуулъя. Та нар гараа өргөчих. Тэгээд унавал тэр биз. Тэгэхдээ үнэтэй л болно. Юу гэсэн үг юм? Маргааш хуралдахгүй уучлаарай. Энэ саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөх үү? Тийм үнэ нь хямдрах байхгүй юу? 8 уу? Тэгэхээр чинь дэмжигдэхгүй. Үгүй ээ үгүй энэ дэмжигдэхгүй бол нөгөө нэг хуулийн төслөөрөө л үлдчихнэ шүү дээ. Шилжинэ гэдгээрээ л үлдчихнэ шүү дээ. Яах вэ тэд нар нь тэгээд л дараа нь л оруулж ирнэ биз. Нийслэлээс шилжих, тэр ингээд хуулийн төслөөрөө л явчихна шүү дээ. Хуулийн төсөл нь л үлдэнэ. 17-гоос 8, дэмжигдсэнгүй. Өөр юм, дараагийн хууль нь юу билээ?

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийн 1 дүгээр зүйл, заалттай холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн, эхлээд 1-ийг дуусгасан, 2 дугаар хавсралтыг хэлэлцэж эхэлье. Асуулт асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Үг хэлж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Биш ээ энэ чинь өөр шүү дээ, нөгөө өөр хууль. Ингээд Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

**Юу гэнэ вэ?** Ганхуяг гишүүн горимын санал. Ганхуяг гишүүн горимын санал.

**Х.Ганхуяг:** Тэгээд энэ чинь даргаа үг ч хэлэх боломж байхгүй. Тэгээд сая энэ Чойжилсүрэн гишүүн.../үг тасрав/

**Ц.Даваасүрэн:** Өөр хууль хэлэлцэж байгаа учраас.

**Х.Ганхуяг:** Тэрийг мэдэж байгаа даргаа. Тэгээд сая Тавантолгой түлитэй холбоотой асуудал дээр тэр тусмаа яг Чойжоо гишүүн бол энэ асуудал дээр уг нь саналаа өгөх гэж байж байсан байхгүй юу. Тэгээд яг өөрийнхөө эрхлэх асуудлын хүрээнд, тэгээд Нийслэлийн Засаг дарга энэ тэр гээд асуудлууд байгаа болохоор энэ саяын тэр 7 дугаар асуудлын 2 дахь санал

хураалтыг маргааш өглөө явуулж өгнө үү гэж хүсэх гэсэн юм. Яг чуулган эхлэхийн өмнө 10 минутын өмнө. Тэгээд энэ чинь асуудлаа шийдэхгүй, бид нар асуудлаа шийдээд дуусгачихъя л даа энэ. Тэгэхгүй бол ингээд л нэг өртэй юм яваад л байдаг, сайжирдаг ч үгүй, яадаг ч үгүй.

**Ц.Даваасүрэн:** Ганхуяг гишүүний гаргасан горимын санал. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, маргааш дахиж явуулъя гэж байна тийм үү? Ганхуяг гишүүний гаргасан горимын саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Хэд вэ? 17-гоос 4, энэ санал дэмжигдсэнгүй. Байж байгаарай, байж бай. Одоо 1 хууль уншина байж байгаарай.

Монгол Улсын 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Ингээд, эхнийх нь хаана байна вэ? Эхнийх нь энэ. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд биш ээ, Төсвийн хүрээний мэдэгдлийг нь эхлээд, Төсвийн хүрээний мэдэгдлийнх нь хаана байна вэ? Тэрийг нөгөө би хууль, нөгөө. Би хүн томилчихсон юм уу? Томилчихсон юм уу? Хэнийг томилсон билээ, төсвийн хүрээ дээр хэнийг томиллоо, томилоогүй шүү дээ чи орхичихсон байна гээд надад тэгээд байсан шүү дээ. Томилоогүй дээ, би гишүүн томилоогүй шүү дээ унш гэж. Аубакир томилчихсон уу?

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг саналаараа танилцуулчих гишүүн хэн байна вэ? Заяабал гишүүн танилцуулах уу? Заяабал гишүүн

чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 00.38 цагт

Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Ирсэн гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА